

**ӨРГӨДЛИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-33

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 4-33

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
09 дүгээр сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа, Д.Рэгдэл;

Чөлөөтэй: Г.Лувсанжамц;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга;

Тасалсан: Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, аудитын менежер С.Нацагдорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар, Н.Энхбаяр, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Анар, мөн банкны Санхүүгийн зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал Б.Цэнд-Аюуш, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Уянга, Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Ням-Очир, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Төсвийн хүрээний мэдэгдлийн төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын

дарга Л.Ичинноров, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, ахлах шинжээч Н.Уранцэцэг, Д.Отгонжаргал, Г.Үлэмждэлгэр, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мэргэжилтэн Р.Хангал, О.Гантулга, Боловсролын яамны Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга А.Мөнх-Оргил, мөн хэлтсийн ахлах шинжээч Э.Адъяасүрэн, шинжээч Б.Түмэнбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Болорсүх, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Бауыржан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэд дарга Л.Ариунзаяа, Нийслэлийн Засаг даргын Замын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Л.Хосбаяр, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Аз, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Б.Даваадалай, мөн компанийн Стратеги, бизнес хөгжлийн газрын дарга Б.Мэндбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, М.Мандхай нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Х.Баасанжаргал, Ц.Мөнхтуяа, О.Саранчулуун, Ж.Галбадрах, Ж.Золжаргал, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга А.Мөнх-Оргил, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний мэдэгдлийн төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Б.Даваадалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Ц.Мөнхтуяа, О.Саранчулуун, Ж.Галбадрах нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 48 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 31 минут.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Нийт 21 гишүүнээс 11 гишүүн буюу 52.4 хувь ирцдээ орсон байна. Ирцэд Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар орсон байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр нэг асуудал хэлэлцэнэ. Ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудал буюу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын хороогоор хэлэлцэх гэж байна. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна, хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Өнөөдөр, Сангийн сайд хаана байна вэ? Гол төсвийн тодотголоо танилцуулж байгаа Сангийн сайд юм уу Хэрэг эрхлэхийн сайд орж ирэх ёстой, Сангийн сайдыг дуудаарай. Эсхүл Хэрэг эрхлэхийн сайд юм уу аль нэг нь орж ирж танилцуулах ёстой Өргөдлийн байнгын хороон дээр.

Засгийн газрын гишүүдээс ХХААХҮ-ийн сайд Идэрбат ирсэн байна. Үндэсний аудитын газраас Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд ирсэн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгдорж ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ринчинбазар ирсэн байна. Монголбанкнаас Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Анар ирсэн байна. Монголбанкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал Мөнхбаяр ирсэн байна. Монголбанкны Мөнгөний

бодлого, судалгааны газрын Макро эдийн засгийн шинжилгээ, судалгааны хэлтсийн захирал Цэнд-Аюуш ирсэн байна. ЗГХЭГ-аас, сайдтайгаа хамт орж ирнэ. Яагаад нэрээ урьдчилж өгдөггүй юм, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантуяа байна уу, нэрээ өгчхөөд, Хэрэг эрхлэхээс хэн байгаа юм бэ? Хэрэг эрхлэхээс дуудаач, энэ чинь олон салбарын асуудал байгаа. Өргөдлийн байнгын хороон дээр ирж байгаа асуудал чинь бид ЗГХЭГ, Хяналт хэрэгжүүлэх газартай л хамгийн ойр ажиллах ийм чиг үүрэгтэй Байнгын хороо шүү дээ. Хэрэг эрхлэхээс хүн дуудаарай.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Хянан шалгалтын газрын дарга бөгөөд ахлах хянан шалгагч Баясгалан, Тандалт, судалгаа, бодлогын төлөвлөлтийн газрын дарга Баярмаа ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ байгаа юм уу? За. Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Мягмардорж ирсэн байна. Сангийн яамнаас Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Чимидсүрэн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ичинноров, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Содномдаржаа, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Гантулга, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Хангал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн Гантулга оролцож байна.

Боловсролын яамнаас Боловсрол, эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга Мөнх-Оргил, Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын ахлах шинжээч Адьяасүрэн, Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын шинжээч Түмэнбаяр нар оролцож байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ТНБД Даваажаргал оролцож байна, НДЕГ-ын дарга Батжаргал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Бавуу Бауыржан, Бауыржан арга яасан, дуудаарай. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэд дарга Ариунзаяа оролцож байна. Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамнаас ТНБД Баяраа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Уянга, Нийтийн аж ахуй, бодлого, зохицуулалтын газрын дарга Ням-Очир нар оролцож байна. ХХААХҮЯ-наас Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Болорсүх нар оролцож байна. ЭМЯ-наас ТНБД Эрдэнэбаяр, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Мөнхцэцэг, ЭМД-ын Бодлого, зохицуулалтын газрын дарга Отгонбаатар, ЭМД-ын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын Эдийн засаг, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга Батхуяг оролцож байна. ЭХЯ-наас ТНБД Ерэн-Өлзий, Хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн нар оролцож байна.

НЗДТГ-аас НЗД-ын Замын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Хосбаяр, НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Эрдэнэбадрах, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Аз нар оролцож байна. Мөн Чингис хаан баялгийн сан нэгдэл ХХК-иас Чингис хаан баялгийн сан нэгдэл ХХК-ийн захирал Даваадалай, Чингис хаан баялгийн сан нэгдэл ХХК-ийн Стратеги, бизнес хөгжлийн газрын дарга Мэндбаяр, Чингис хаан баялгийн сан нэгдэл ХХК-ийн Санхүү, бодлогын газрын дарга Зоригтбат нар оролцож байна. Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ гэж заасан. Манай Өргөдлийн байнгын хорооны хувьд эрхлэх асуудлын хүрээнд иргэдээс ирж байгаа өргөдөл гомдол, мөн d.petition системээр УИХ-д өргөдөл саналаа хүргүүлж байгаа иргэдээс гаргасан саналтай холбоотой энэ асуудал дээр бид төсвийн хүрээний төсвийн тодотгол болон төсөвтэй холбоотой асуудал дээр байр суурь, хэлэлцүүлгийг хийдэг байгаа. Тэгээд гишүүд маань жил гаруй хугацаанд иргэдээс орж ирж байгаа өргөдөл, d.petition дээр явж байгаа иргэдийн цахим саналуудтай холбоотойгоор төсвийн тодотгол дээр хэрхэн яаж туссан, ямар үр дагавар гаргахтай холбоотой асуулт асууж, үг хэлнэ гэж Дэгийн хуулиар заасан байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Баасанжаргал гишүүнээр тасаллаа, нийт 6 гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу бүгдээрээ. Яг жилийн өмнө бид энд сууж байгаад эрүүл мэндийн эмч, эмнэлгийн ажилчид, тэнд ажиллаж байгаа бүх хүмүүсийн цалинг 50 хувиар нэмье гэдэг саналыг гаргаад, холбогдох Байнгын хороодоороо дэмжээд, УИХ-ын чуулган дээр дэмжээд яг явсан. Дэлгэрсайхан сайд тухайн үед нь дахиж санал оруулж байгаад 3 хүний саналаар зөрүүтэй энэ саналыг унагааж байсан. Тэгэхдээ цалинг яах аргагүй нэмэх шаардлагатай 50 хувиар гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ удаа Засгийн газар тооцоотой, тооцоололтой, яг эх сурвалжтай нь оруулж ирж байгаад баяртай байгаа. Тэр утгаараа ч гэсэн ерөнхийд нь энэ төсвийн тодотголоор орж байгаа зардлыг нийтэд нь дэмжиж байгаа гэдгийг хэлье.

Энэ дээр 2 дахь хэсэг нь юу байсан бэ гэхээр, эрүүл мэнд, эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө ер нь төрийн албан хаагчдын цалин мөнгө ярихаар бид бүтээмжтэй холбогдох цалингийн тухай заавал ярих ёстой байдаг, бусад улс, хөгжилтэй орнуудад ч гэсэн тийм байдаг. Бүгдийг нь хавтгайгаар нь цалин нэмэхээсээ илүүтэй хийж байгаа ажлын гүйцэтгэл, үнэхээр ажлын цаг ачаалалтай нь уяж, тэр цалингийн бүтээмжийн чанарыг дээшлүүлэх энэ асуудлыг зайлшгүй ярих ёстой, энэ засаг тийшээгээ явж байгаа гэж би ойлгож байгаа. Энэтэй холбоотой 2, 3 асуултыг тодруулъя.

1 дүгээрт, ЭМД-ын санг өргүй болчихсон байгаа, тэнцэл нь эерэг гарсан их сайн мэдээтэй байгаа, өнгөрсөн хавар бид чуулган тарах үед энийг ярьж байсан. Гэхдээ эмнэлгүүд өртэй байгаа тийм үү? Тэр хэдэн эмнэлэг, ямар эмнэлэг, хэр зэрэг өртэй байгаа, энэ эмнэлгүүдийн нэхэмжлэл нь хойшилж байгаа юу, тусламж үйлчилгээний тоо хязгаарлагдаж байгаа юу? Хязгаарлагдаж байгаа бол хаана илүү хэр хязгаарлагдаж байна, иргэн эмнэлгээс эм хэрэгсэл үйл ажиллагаа явуулахад ямар саад бэрхшээл тохиолдож байна? Одоо яг зарлагыг бууруулахад юм уу, дахин хуваарилахад ямар тусламж үйлчилгээ хамгийн их өртөх вэ гэдэг асуудал надад байна.

Тэгэхээр 2 асуулт байх нь байна шүү дээ. 1 дүгээрт, хэр зэрэг өртэй байна, тэр өрний асуудлыг яаж шийдэж байгаа юм, хаана хаана аль эмнэлэг дээр? 2

дугаарт, ЭМД-ын сангийн тэнцлийг бууруулах юм уу, дахин хуваарилж байгаа яг ямар тусламж үйлчилгээ илүү өртөх юм бэ? Ялангуяа бид нарын зүрх судасны өвчлөл ч юм уу, хавдар ч юм уу, диализ /dialysis/ ч юм уу, эх үрсийн тусламж үйлчилгээний тал дээр, тэгээд яаралтай тусламж зайлшгүй энэ дээр яригдах ёстой хамгийн чухлууд нь. Эдгээр дээр бид ямар бодлого байгаа юм, яаж энийгээ зохицуулж байгаа юм, яаж энийгээ хамгаалж үлдэж байгаа юм бэ? Хот, хөдөөгийн эмнэлгүүдийн энэ дээр ялгаа байгаа юу, үгүй юү гэдгийг асуучихмаар байна. Хэдэн минут байна вэ, 1 минут 20 секунд. Хэрвээ энэ хүртэл эхлээд асуучихъя.

О.Номинчимэг: Ганмаа гишүүний асуултад ЭМЯ хариулах уу? 9 номер.

Н.Эрдэнэбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая, ЭМЯ Эрдэнэбаяр. Ганмаа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын 25 оны жилийн эцсийн байдлын өрийг авч үзвэл, нийтдээ 240.1 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байсан, ЭМД-ын сангаас эргээд 141.1 тэрбум төгрөгийн авлагатай ингэж гарсан байсан. Энэ өр авлагуудыг ингээд багцлаад аваад үзэхээр, 61.9 тэрбум төгрөг нь татвар, НДШ-ийн өр, 130 тэрбум төгрөг нь эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын ийм өр төлбөрүүд гарсан байсан. Энэ төсвийн тодотголтой холбоотойгоор бид энэ 8 сарын 30-ны байдлаар эмнэлгүүд өрийг нэгтгэж ингэж гаргаж явж байгаа. Энэ дээр бид нарын гаргасан тоон мэдээллээс аваад үзвэл, энэ өрийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэйгээс нэг бага зэргийн л буурсан байна лээ, 225 орчим тэрбум төгрөгийн ийм өрийн асуудал байж байгаа. Энэ яг ангиллаар нь аваад үзвэл, үндсэндээ нийгмийн даатгалын татвар, нийгмийн даатгалын өрүүд, тэгээд эм, эмнэлгийн хэрэгслийн өр гэсэн ийм 2 үндсэн ангилал дээр энэ өрүүд байж байгаа гэдэг ийм нарын гаргасан энэ 8 сарын эцсийн гүйцэтгэлээрээ ингэж гаргасан юмнууд байж байгаа.

Энэ өрнүүдийг бид цаашдаа бууна гэж харж байгаа. Яагаад гэхээр ЭМДҮЗ-ийн тогтоолоор энэ гүйцэтгэлийн санхүүжилт, даатгалаар энэ оношны хамааралтай бүлгүүдийн санхүүжилт дээр тодорхой зохицуулгууд орж өгсөн. Энэ маань яг Хууль зүйн яаманд албан ёсоор бүртгэгдээд ингээд 7 сараас ингэж хэрэгжиж эхэлсэн. Тэгээд энэ дунд нэг ийм завсрын хугацаа үүссэнтэй холбоотой өр авлагын хэмжээ төдийлөн буурч чадаагүй байна гэж ингэж дүгнэсэн. Энэ оны эцэс дээр гүйцэтгэлээрээ нэлээн буурах ийм боломжууд байна гэдэг байдлаар ингэж тооцогдож гарч ирсэн байгаа. Тэгээд хэрвээ танд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол бид бүх эмнэлгээр нь энэ мэдээллүүдийг багцалж гаргасан ийм тоон мэдээнүүд бид дээр байгаа.

Хот, хөдөө дээр төдийлөн том ялгаанууд, Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлгүүд дээр, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн ийм эмнэлгүүд дээр нэлээн том хэмжээний өрүүд үүсэж байгаа эмнэлгүүд байгаа. Ер нь энэ нь нэлээн эерэг үзүүлэлттэй ийм эмнэлгүүд байж байгаа. Орон нутгийн хэмжээн дээр зарим нэг алслагдсан дүүрэг, Налайх, Багануур гэдэг юм уу, зарим аймгууд дээр энэ өрийн асуудлууд байж байгаа. Даатгалын энэ зардлын дахин хуваарилалтын асуудал дээр бид энэ төсвийн тодотголтой холбоотой үндсэндээ даатгал тал дээр 79.3 тэрбум төгрөгийг улсын төсөв дээр тусгаж өгч байгаа. Тэгээд яг энэ Эрүүл мэндийн сайдын багцын хүрээн дээр.../минут дуусав/

О.Номинчимэг: 9 номер хариултаа дуусгая. Нэмэлт мэдээлэл.

Н.Эрдэнэбаяр: Сайдын багцын 49 эрүүл мэндийн байгууллага дээр бид 10.9 тэрбум төгрөгийн ийм нэмэлтийг ингэж оруулж ингэж тодотгож байгаа. Даатгалын сан тал дээр ямар нэгэн байдлаар хасалт хийгдэхгүй учраас 26 оны төлөвлөлтөөрөө ингээд явагдаад ингээд явна. Өөрөөр хэлбэл, энэ дээр яг батлагдсан зардлын дагуу зарцуулалтууд ингэж үргэлжилж явахаар бид тооцож ажиллаж байгаа. Оны төгсгөл дээр ер нь 4 дүгээр улирал дээр хийгдэх юмнууд энэ урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ажлуудыг зохион байгуулах энэ тэр гээд гүйцэтгэл нь сул байгаа ажлууд явагдана. Тэгэхээр энэ зардлууд яг батлагдсан төсвийн дагуу явагдахаар ийм зурагтай байгаа.

О.Номинчимэг: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Асуултыг чинь нэгтгээд хариулбал ингэж байна, тийм үү? 1 дүгээрт, ер байгаа, одоо ч гэсэн өртэй байгаа, тэгэхдээ 7 сард энэ ер нь буурна. Яаж буурах гэж байгаа гэсэн үндэслэл нь их ойлгомжгүй тайлбар, оношны хамааралтай бүлгийн зохицуулалтын 7 сараас ЭМД-ын үндэсний зөвлөлийн тогтоол гараад энэ засагдчихна гэдгийг би ойлгохгүй байна уу, эсхүл өөрийн чинь наад тайлбар чинь ерөөсөө ойлгогдохгүй байна. Энэ дээр нэг жоохон тодруулаад өгөөч, яг яана гэнэ вэ, энэ өрөө яаж гүйцэтгэлээрээ засагдах гээд байгаа гэнэ вэ гэдгээ.

2 дугаарт, ЭМД-ын сангийн зардлыг энэ чигээр нь урьд нь төсвийн тодотголоосоо үл хамаараад зарцуулагдах газраа зарцуулагдана. Тэгээд түрүүний миний асуусан гол өвчлөл, гол нас баралтад хүрээд байгаа шалтаг, шалтгаантай энүүгээр ер нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт ч, хүртээмжид ч, ер нь үйлчлүүлж байгаа тоонд ч гэсэн өөрчлөлт гарахгүй юм байна гэж хариуллаа гэж ойлголоо, зөв үү?

О.Номинчимэг: 9 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад тодруулж хариулъя. Ер нь бид тусламж үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн тарифыг нэмэгдүүлсэн, 8 хувиар. Тэгэхээр энэ болон бусад зохицуулалтын арга хэмжээний үр дүнгийн нөлөө нь оны эцэс хүртэл үргэлжлээд санхүүжилт нь олгогдох тул, олгогдож ингэж явахаар тул хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагуудын ер төлбөр үе шаттайгаар буурна гэдэг ийм тооцооллуудыг бид яг хийгээд байгаа юм. Тэгээд энийг бид энэ 7 сараас хэрэгжиж эхэлсэн энэ өөрчлөгдсөн тогтоолын хэрэгжилттэй холбоотой нь яг энэ тухайлсан эрүүл мэндийн байгууллагууд дээр яг өр авлагатай байгаа болон өрийн асуудал харьцангуй сайн үзүүлэлттэй байгаа ийм байгууллагуудыг ингэж харьцуулж, ийм нарийвчилсан судалгаанууд хийж, энэ дээр тооцооллууд хийгдэж байгаа гэдгийг тодруулж хэлье. Энэ өвчлөл, нас баралтын асуудлууд жилийн эцсийн статистик тоон мэдээллүүдээр дүгнэж гарах учраас бид энэ дээр яг шууд хэлэхэд хангалтгүй байна гэдгийг хэлье. Түрүүн нэг KPI-ын асуудлууд ярьсан байгаа, энэ дээр Засгийн газар.../минут дуусав/

О.Номинчимэг: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Боловсролоос асууя, Боловсролын яамнаас хүмүүс байгаа тийм ээ? Өргөдлийн байнгын хороон дээр боловсролын асуудал, тэр дундаа улсын сургууль, ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-д суралцаж байгаа хүүхдүүдийн оногдож байгаа зардал, үдийн хоол, цай гээд ингээд боловсролын тэгш хүртээмжтэй холбоотой маш олон өргөдлүүд ер нь ирдэг. Тийм учраас би энэ Өргөдлийн байнгын

хороон дээр илүү энэ боловсролтой холбоотой асуултыг тодруулж асууя. Төсвийн тодотгол гэдэг маань үлдсэн дараагийн 3 сард бид нарын баталж өгөх мөнгийг 1 дүгээрт зарцуулна. 2 дугаарт, өнгөрсөн онд энэ оны төсвийг хэлэлцэхэд бид энэ сургуулийнхаа ачааллыг, хүүхдүүдийнхээ тоо гээд энэ зүйлүүдийг дутуу тооцоолсон байгаа учраас 50 тэрбум нэмэлтээр зардал хэрэгтэй байна буюу гэрт ойр сургууль, 50 тэрбумыг бид одоо батлах гэж байна гэж ойлгоод байгаа. Тэгээд энэ 50 тэрбумтай холбоотой задаргааг харахаар хэд хэдэн тоонууд анхаарал татаж байна. Энэ дээр та бүхэн өөрсдөө тайлбар өгөөрэй.

1 дүгээрт, энэ хувьсах зардал гээд нийтдээ 2.3 тэрбум төгрөгийг 3 хувийн сургуульд, ахлах сургуульд, 3 хувийн ахлах сургуульд нийтдээ мянган хүүхэд сургана гэж өгчээ. Гурвуулаа Хан-Уул дүүрэгт байдаг сургууль байна. Дараа нь орчин сайжруулах гээд биш, 3 дугаарт, төрөлжсөн ахлах сургуульд шаардлагатай тоног төхөөрөмжийг сайжруулах гээд ингээд Нийслэлийн Оюуны ундраа, Нийслэлийн 157, Сонгинохайрхан дүүрэг СХД гээд ингэж явж байгаад энэ дотор нь дахиад 2 хувийн сургуулийн тоног төхөөрөмжийг сайжруулах гэдэг ийм зардал орж иржээ. Хан-Уул дүүргийн нэг сургууль, СХД-ийн нэг сургууль, тэр дундаа энэ СХД-ийн сургууль нь хамгийн өндөр зардал буюу 3.5 тэрбум төгрөгийг энэ төсвийн тодотголоор авах гэж байна. Энэ хувийн сургуулиудад, энэ 4, 5 ийм хувийн сургуулиудад төсвийн тодотголоор яагаад энэ мөнгийг өгөх зайлшгүй шаардлага үүссэн бэ, яагаад дандаа Хан-Уул дүүргийн сургууль байгаа вэ гэдэг нэг дэх асуулт?

2 дахь асуулт юу вэ гэвэл, энэ сургуулийн ачааллыг энэ 26 оны төсөв дээр орж ирэх бүрэн боломжтой. Өнөөдөр ахлах сургууль, дунд ангид ирэх жил хэдэн хүүхэд суралцах вэ, орох вэ гэдэг нь маш тодорхой статистик байдаг. Энэ тооцооллыг яагаад бид өнгөрсөн онд хийж чадаагүй юм, энэ яам яагаад энэ тооцооллыг зөв хийж чадаагүй одоо ингээд ийм зардлыг нэмж оруулж ирж байгаа вэ гэдэг дээрээ нэг тодорхой тайлбар өгөх хэрэгтэй байна 2 дугаарт?

3 дугаарт, төсвийн тодотгол дээр дахиад анхаарал татсан 3 дахь нэг тоо байгаа, 3 улсын сургууль мөртөө олон улсын хөтөлбөртэй, 3 улсын сургуульд нэмэлт 3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор ийм тоо гарч ирсэн. Шинэ эрин олон улсын хөтөлбөрийн сургалттай сургууль, Шинэ эхлэл, Монгол тэмүүлэл, 1 тэрбум, 975, 985 гээд ингээд нийтдээ 3 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт төсвийн тодотголоор олгох гэж байна. Энэ бодвол багш нарын цалин байгаа байх. Тэгэхээр улсын сургуулийн багш нарын цалин улсын сургууль дотроо дахиад олон улсын хөтөлбөртэй гуравхан сургуулийн багшийн цалин ийм 3 тэрбумаар ялгаатай байдаг юм уу? Тэгэхээр олон улсын хөтөлбөртэй сургуулийн багш нар хэдэн төгрөгийн цалин авдаг юм, энгийн улсын сургуулийн багш нар хэдэн төгрөгийн цалин авдаг юм, яагаад төр өөрийнхөө мөнгөөр ийм боловсролын тэгш бус байдлыг бий болгоод байгаа юм бэ? Энэ дээр нэг тайлбар хэлээдэхье.

О.Номинчимэг: Боловсролын яам хаана байна вэ? 5 номер, өөрийгөө танилцуулаад гишүүний асуултад хариулъя.

А.Мөнх-Оргил: Боловсролын яам, Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газрын дарга Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Ер нь нийслэлийн ачааллыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр энэ хичээлийн жилээс төлөвлөж ажилласан. Мэдээж өмнөх жилүүдэд нийслэл ялгаагүй бүлэг дүүргэлтийн өндөр ачаалалтай байсан. Энэ хичээлийн жилд нийслэлийн 77 ЕБС 46-аас дээш суралцагчтай 1089 бүлэг хичээллэхээр байгаа. Энэ цогц арга хэмжээг

хэрэгжүүлснээр бид 971 бүлгийн бүлэг дүүргэлтийг бууруулж байгаа. Өмнөх жилүүдэд ачааллыг бууруулах зохицуулалтыг ихэвчлэн хүртээмжийг нэмэгдүүлэх буюу сургуулийн барилгыг шинээр барих замаар шийдэж байсан. Гэхдээ өнөөдрийн төсвийн нөхцөл байдал, одоо баригдаж байгаа барилгын тоо хэмжээ, одоо шаардлагатай байгаа сургуулийн тоо хэмжээг ерөөсөө гүйцэхгүй байгаа. Хэдийгээр Боловсролын яам Сангийн яамтай хамтран улсын төсөв дээр ч барилгууд барьж байна, мөн Дэлхийн банк, АХБ-тай хамтран төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад эх үүсвэрүүдээс барилгыг барьж байгаа боловч эдгээр гэрт ойр сургууль, энэ хотхоны бага сургуулиудын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол яг одоо байгаа энэ өндөр бүлэг дүүргэлт, ачааллыг бууруулах аргагүй байсан учраас энэ арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн.

2 дугаарт, тэр хувийн сургуулиудад өгч байгаа, тэр яагаад Хан-Уул дүүрэг байгаа вэ гэхээр Хан-Уул дүүргүүдэд жишээ нь яг тэр 3 сургууль байгаа хотхон, хороололд нэг ч улсын сургууль одоогоор барилга байхгүй байгаад байгаа. Ийм учраас яг тэнд байгаа хувийн сургуулийн бүтэн барилга дээр хүүхдүүдийг сургаад, тэрэнд шаардлагатай хувьсах зардлыг хувийн хэвшилтэй хамтран хувьсах зардлыг нь өгөөд, бүрэн өгөөд, тэгээд хувийн сургуулиар хэрэгжүүлэх ийм арга хэмжээ санаачилсан учраас энэ дээр зуны ажилласан ажлын хэсгүүдийн дүгнэлт гараад яг боломжтой гэсэн байршлууд дээр хувийн 3 сургуультай, одоогоор эхний нэг л сургууль дээр гэрээ байгуулагдаад хичээл эхлэх гэж байна. Ингээд цаашдаа үргэлжлүүлээд явна. Мэдээж улсын төсвийн болон бусад эх үүсвэрийн барилгууд баригдаад сургуулиуд ашиглалтад ороод ирэхээр энэ түр зуурын арга хэмжээ, цаашид үргэлжлүүлэн хэрэгжихгүй гэж үзэж байгаа. 1-ээс 3 жилийн хугацаанд хэрэгжих болов уу гэж бид төлөвлөж байна.

3-д нь болохоор олон улсын хөтөлбөртэй сургуулийн би гишүүнд дараа нь албан бичгээр тоо дүнг нь нэлээн дэлгэрэнгүй өгье. Ер нь Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан олон улсын хөтөлбөртэй сургуулийн багш нар ердийн сургуулийн багш нараас 50 хувийн нэмэгдэл цалинтай байдаг. Энэ Засгийн газрын тогтоолоор тогтоосон сүүлийн байгуулагдсанаас хойш авч байгаа нэмэгдэл. Ийм учраас эдгээр сургуулиудын цалин хөлс бусад сургуультай адил нэмэгдсэн учраас тэр санхүүгийн эх үүсвэр л зөвхөн улсын төсвийн тодотгол дээр батлагдаж орж ирсэн байгаа.

4 дүгээрт, тэр төрөлжсөн ахлах сургуулиуд байгаа. Төрөлжсөн ахлах сургуулиудыг яагаад хэрэгжүүлэх гэж байна гэхээр хүүхдүүдийг сонгоныг бид нарын хуучин сонгон гэж ярьдаг, энэ төрөлжсөн сургалт сайтай сургуулиудад зөөж байгаа, заавал тэр сургуулиудыг сонгохгүйгээр дүүрэг болгонд төрөлжсөн сургалттай, ялангуяа энэ жилийн хувьд байгалийн ухааны төрөлжсөн сургалттай сургуулийг.../минут дуусав/

О.Номинчимэг: 5 минут гүйцээж хариулъя. Нэг минутад гүйцээгээд хариулаадахъя.

А.Мөнх-Оргил: Энэ төрөлжсөн сургуулиудыг дүүрэг болгонд байгуулж, цаашдаа аймгуудад байгуулаад хүүхдүүдийг ялангуяа энэ жилийн хувьд байгалийн ухааны хичээлээр төрөлжин сургаж суралцах, байршил харгалзахгүй нөгөө гэрт ойр орчиндоо суралцах боломжийг бүрдүүлэхийг зорьж байгаа. Энэний хүрээнд энэ тодотгол дээр тавигдчихсан байгаа, төлөвлөгдчихсэн байгаа 10 тэрбум, 15 тэрбум төгрөг дандаа байгалийн ухааны хичээлийн лабораториуд байгаа юм эд нарыг

ингээд сургуулийнх нь яг шинээр хөтөлбөр нь батлагдчихсан үйл ажиллагаа эхлэх боломжтой сургуулиуд дээрээ төлөвлөж тавьсан. Цаашдаа дараагийн жилүүдэд бусад орон нутгийн төрөлжсөн сургуулиудад байгалийн ухааны лабораториор хангаад ингээд сургалтын орчныг бүрдүүлээд суралцуулахаар зорьж байгаа, баярлалаа.

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: 1 дүгээрт миний асуулт ингээд байгаа юм. Төрөлжсөн ахлах сургуулийг тоног төхөөрөмжтэй болгоно гээд байгаа дотор чинь 2 хувийн сургууль байна, уг нь дандаа улсын сургуулиудыг тоног төхөөрөмжтэй болгох гээд байна гэж харж байна. Бусад сургуулиудыг нь харахаар. Гэтэл энэ дотор 2 хувийн сургуулийг тоног төхөөрөмжтэй болгоно гээд байна, энэ болох юм уу, энэ бодлоготой чинь нийцэж байгаа юм уу, нэг дэх асуулт?

2-т нь тэр зөвхөн Хан-Уул дүүрэг яагаад сонгогдсон гэдэг чинь анхаарал татаад байгаа байхгүй юу. Ачааллуудыг хэрвээ харах юм бол Хан-Уул дүүргээс гадна БЗД, ЧД, СХД гээд маш өндөр ачаалалтай сургуулиуд байгаа шүү дээ. Бусад улсын сургуулиуд. Өнөөдөр бүгд цахим орчинд, хүүхдүүд өнөөдөр номоо аваагүй байж байна шүү дээ өнөөдрийн байдлаар, 1 дүгээр ангийн хүүхдүүд номоо аваагүй байна, 6 дугаар ангийн хүүхдүүд номоо аваагүй байна, ангийнх нь 5 хүүхэд номоо авчихсан. Гэтэл бид нар ингээд энэ бусад сургуулиудын ийм хувийн сургуулиудад яагаад энэ байгаа мөнгөө.../минут дуусав/

О.Номинчимэг: Хэн тайлбарлах вэ? Төрийн нарийн нь PISA-гийн нээлт болоход өөрөө онлайнаар илтгэл тавих ёстой гээд Төрийн нарийн чөлөө авсан, сайд Францад албан айлчлалтай байгаа юм байна. Яагаад хувийн тийм хувийн сургуулиудын асуудлыг, ялангуяа нэг дүүрэг дэх байгаа асуудлуудыг дэмжээд бусад улсын сургууль дахь юмнуудаа анхаарахгүй байна гэдэг юм энэ төсвийн тодотголоос харагдаад байна гэдэг асуулт. Хэн хариулах вэ? 5 номер.

А.Мөнх-Оргил: Мөнх-Оргил, гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь яагаад Хан-Уул дүүрэг дээр энэ хувийн сургуулиуд сонгогдсон бэ гэхээр зуны хугацаанд энэ ачааллыг бууруулах, эдгээр бүлгүүдийн ачааллыг бууруулахаар ажлын хэсэг байгуулагдаад НБГ-аас нийслэл дээр сар гаруй хугацаанд 43 байрлал дээр зарлал тавьсан. Энэ 43 байршлаас 38 байршил дээр одоо байгаа сургууль болон цэцэрлэгийн хүүхдийн тоо буурч байгаатай холбоотой зарим цэцэрлэгийн барилгыг сургууль болгон ашиглах боломжтой ийм зохицуулалтыг хийссэн. Энэ зохицуулалт хийгдээд зарлаад үнэхээр байр олдоогүй тэр 3 байршил дээр, Хан-Уул дүүрэг дээр яалт ч үгүй хувийн сургууль дээр өнөөдөр үйл ажиллагаа явуулахаар хийгдсэн байгаа. Хэрвээ цаашдаа түрээслэх боломжтой юм уу, тэнд улсын сургууль байгуулагдсан тохиолдолд тухайн хувийн сургуулиуд дараа дараагийн жилээс хийгдэхгүй ингээд явах юм.

2-т нь тэр хувийн сургуулиудын тоног төхөөрөмжтэй холбоотойгоор яах вэ, зүгээр энэ хувийн сургуулиудад түр ашиглуулах л болохоос биш.../минут дуусав/

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүн тодруулга.

Х.Баасанжаргал: Төр ашиглуулах тоног төхөөрөмж хувийн сургуульд 6 тэрбум төгрөгөөр бид авч өгч байгаа юм уу? Татвар төлөгчийн мөнгөөр 2 хувийн

сургуульд 6 тэрбум төгрөгөөр шүү дээ, нийлүүлбэл бараг 7 тэрбум төгрөг болж байна. Нэг нь 3.5 тэрбум, нэг нь 3.6 тэрбум. Тэнд хэдэн хүүхэд сурах юм, хэний хүүхэд сурч байгаа юм? Гэтэл улсын сургуулийн хүүхдүүд өнөөдөр сурах бичиггүй явж байна гээд яагаад энэ боловсролын тэгш бус байдал руугаа энэ мөнгө чинь орохгүй байгаа юм бэ? Яг энэ асуултад хариулаадах даа, түр ашиглуулах юм бол хэдэн жилийн хугацаатай өгөх юм, хэзээ тэгээд буцаагаад авах юм бэ? Тоног төхөөрөмжийн элэгдлийн хугацаа 3 жил байдаг, 3 жилийн дараа энэ тоног төхөөрөмж чинь юу ч биш, балансаас шууд хасагдана, тэг болоод л дуусна. Улс юу авч чадах юм бэ? Энийг Эдийн засаг, хөгжлийн яам мэдэж байгаа юу, Сангийн яам мэдэж байгаа уу, ингэж мөнгө өгч болох юм уу, ингэж түр тоног төхөөрөмж хувийн сургуульд өгч болох юм уу, хуульд нийцэж байгаа юм уу, Төсвийн тухай хуульд?

О.Номинчимэг: Сангийн яам хаана байгаа билээ, Сангийн яам наашаа суугаарай. 5 номер хариулт хийх үү? Яг ямар нөхцөлтэйгөөр аль аль сургуульд, ямар тоног төхөөрөмж гэхээрээ юу төлөвлөхөөд байгаа юм, яагаад ингэж байгаа юм, гишүүний асуултад хариулаад, дараа нь Сангийн яам бэлдээрэй.

А.Мөнх-Оргил: Тэгье, энэ яалт ч үгүй өнөөдөр 9 сарын 1-нд хичээл эхлэхэд тухайн хувийн сургуулиудтай гэрээ байгуулаад, байрыг нь түрээслээд, сургуулиудыг төрөлжсөн байдлаар ашиглахад орчин нь бүрдээгүй байгаа тохиолдолд түр хугацааны дэмжлэг өгч байгаа. Түүнээс энийг тухайн сургуулийн баланст өгөөд бүрмөсөн шилжүүлэх гэж байгаа зүйл байхгүй. Тэгээд би яг тэр тоо дүнг нь дараа нь албан бичгээр дэлгэрэнгүй өгье.

Ер нь ачааллыг бууруулах энэ арга хэмжээ 2-оос 3 хичээлийн жилд хэрэгжинэ үзэж байгаа. Хэрвээ тухайн байршилд бид АХБ-аар 33, Дэлхийн банкаар 43 орчим сургуулийн барилгыг ер нь ихэнхийг нь нийслэлд барих гэж байгаа. Яг тэр зайлшгүй шаардлагатай байршлуудаа, газраа шийдээд барилгаа барьчихсан тохиолдолд заавал хувийн сургууль юм уу, хувийн ямар нэг барилгыг түрээслэх шаардлагагүй болчихно, тухайн үед энэ арга хэмжээнүүд зогсоод явчихна байршил байршил дээрээ.

О.Номинчимэг: Нэмэлтээр тэр Хан-Уул дүүрэгт 3 байршилд, 3 сургуульд хувийн сургуульд тоног төхөөрөмж гэж байгаа юм байна шүү дээ. Яг ямар ямар, аль аль сургууль юм бэ нэрийг нь хэлээдхээч. Тэр сургуулиудаа тодорхойлчихсон бол нэрийг нь хэлээдхээч. 5 номер.

А.Мөнх-Оргил: Яг одоогоор надад дэлгэрэнгүй мэдээлэл нь алга байна, би албан бичгээр өгье.

О.Номинчимэг: Хэн мэдэж байх ёстой билээ энийг, үгүй ээ төсвийн тодотгол оруулж байгаа мэргэжлийн яам дээр нь яг энэ энд ийм бодлого гаргаад ингэнэ гэдгийг нь мэдэхгүй хэн мэдэх ёстой билээ? Нийслэлийн боловсролын газар /НБГ/-аас байгаа билүү?

А.Мөнх-Оргил: Байхгүй, НБГ-аас алга байна.

О.Номинчимэг: Энэ чинь юм нь тодорхой болчихоод орж ирж байгаа биз дээ? Яг ямар хэрэгцээ шаардлага дээр байгаад энэ сургуулиудыг сонгоод ингэсэн юм гэдэг. Боловсролын яамнаас өөр хэн байгаа билээ, яагаад Боловсролын яам энийгээ тэгээд нарийн юмаа мэдэхгүй төсөв дээр мэдэхгүй байна гээд сууж байдаг

юм? Эдийн засаг, санхүү, бодлогын газрын дарга байна шүү дээ, танаар тэгвэл энэ ороогүй гэсэн үг юм уу, энэ нэмэлт төсвийн тодотголын асуудал? Тэгвэл хүмүүсээсээ мэдээллийг нь аваад бэлдэж байгаарай, асууна шүү. Сангийн яам наашаагаа ойртоод суугаарай, микрофон дээр, хэн хариулах юм? Энэ боловсролын тэгш хүртээмжтэй байх бодлого Засгийн газрын хүрээнд улсын сургуулиуд дээр хөрөнгө оруулалт нь нэмэгдэхгүй мөртөө хувийн сургууль дээр ингэж байгаа ямар юм байна вэ? Та хэд яагаад энийг бодлогын хүрээнд окэй зөвшөөрсөн юм бэ? Тэгээд тэр улсын төсвөөр авч байгаа тоног төхөөрөмжийг хувийн сургуульд ашиглуулах энэ дээр ямар нэгэн журам, дүрэм байна уу, ямар хугацаатай байгаа юм бэ, харсан уу гэдэг асуулт байна. 5 номер, нэрээ хэлээд асуултад хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам, Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ, Баасанжаргал гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. Тэгэхээр энэ гэрт ойрхон сургууль арга хэмжээний хүрээнд энэ сургуулийн хүртээмжийг богино хугацаанд нэмэгдүүлэх шаардлага энэ боловсролын салбарт байгаа. Энэ хүрээнд бид 2021 онд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж байсан, энэ схемээ яг сургууль дээр нэвтрүүлж байгаа юм. 21 онд хувийн цэцэрлэгийн сул орон тоон дээр хувьсах зардлыг нь 2 дахин нэмэгдүүлж өгөх байдлаар энэ цэцэрлэгийн хүртээмжийг богино хугацаанд маш хурдан нэмэгдүүлээд явж байсан ийм туршлага байгаа. Гэрт ойрхон сургууль арга хэмжээний хүрээнд энэ сургууль барих, тоног төхөөрөмжөөр хангах, ширээ сандал тавих, багш боловсон хүчнийг нь бэлдээд шинэ сургууль байгуулах энэ арга хэмжээ цаг хугацааны хувьд маш ийм удаан ийм байдаг. Тийм учраас энэ Засгийн газар дээр Боловсролын яам, Сангийн яам энэ концепцоо ярьж байгаад.../минут дуусав/

О.Номинчимэг: Товч тодорхой хариулъя, 5 номер, нэг минутад асуултад хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Гэрт ойрхон сургууль гэсэн энэ цогц арга хэмжээг хэрэгжүүлье. Энэ хүрээнд эхлээд 2026 оны төсвийн тодотгол дээр нийслэлийн хэмжээнд энэ сургуулийн ачааллыг бууруулах энэ арга хэмжээнд маш богино хугацаанд шийдье гэсэн энэ зорилгоор хийсэн. Төрөлттэй холбоотойгоор цэцэрлэгийн орон тоо сулраад, эсрэгээрээ сургуулийн орон тоо хүрэлцэхгүй болчихсон байгаа. Тийм учраас энэ Боловсролын яам дээр туссан энэ гэрт ойрхон сургууль хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ 50 тэрбум төгрөгөөр тодорхой хэмжээнд хувьсах зардлыг нь нэмэгдүүлж өгөх, тэр цэцэрлэгийн зориулалттай барилга байшин дотор сургуулийн тоног төхөөрөмж, ширээ сандал авч тавиад, тэгээд улсын сургуулийн салбар байгуулж ажиллах гэсэн энэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Тэгэхээр энэ хүрээнд яг бидний хувьд яг 9 сарын 1-нд хичээлийн жил эхлэхэд яг энэ арга хэмжээг маш хурдан зохион байгуулж, хүүхдүүдийг сургах ийм хэрэгцээ шаардлага байсан учраас энэ хүрээнд хийсэн ажил байгаа юм.

О.Номинчимэг: Дараагийн гишүүн асуулт асууя. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Саяын Баасанжаргал гишүүний асуулт маш зөв асуулт байна. Хувийн сургуулиудыг л ингээд төрөөс дэмжих бодлого нэлээн яваад, төрийн сургуулиудаа хаях бодлого сүүлийн 30 жилд явсан нь үнэн, үнэн шүү дээ. Тэгээд нэг хэдхэн монопол нөхдүүд хүүхдээр, мөнгө, бизнес хийж байна шүү дээ яг үнэндээ, бүр тийм арга хэрэгсэл нь бүр нарийссан, одоо бүр ингээд тоног төхөөрөмж шилжүүлж байна гээд л хэдэн тэрбумаар нь шилжүүлээд тоглоод сууж байдаг.

Миний асуух гэж байгаа асуулт болохоор итгэлцүүрийн асуудал ярина. 2022 оноос үр дүнгийн санхүүжилт буюу нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар илэрхийлэхэд нь санхүүждэг болсон. Энэ дагуу Засгийн газраас нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүн орон зай, сурагчийн тооноос хамааран итгэлцүүрийг тогтоож ирсэн. Засгийн газрын 26 оны 149 дүгээр тогтоолоор Нийслэл, аймгийн төвийн сургуулийн итгэлцүүр 1501-ээс 1800 хүүхэдтэй үед нэг байсан итгэлцүүр, 1801-ээс 2 мянга гэхээр 0.91 болоод ингээд буурч байгаа. 2001-ээс 2500-д 0.87, 2501-ээс 3 мянган хүүхдэд 0.84, ингээд 3001-ээс 3500-д 0.82, 3500-аас дээш хүүхэдтэй болохоор 0.72 болоод бүр доошоо буурч байгаа юм. Тэгэхээр мунхаг ямар ч хүн, ямар ч тэнэг хүн энд ингэж ойлгоно шүү дээ. Олон хүүхэдтэй тусмаа итгэлцүүр, хувьсах зардал өндөр байх ёстой биз дээ? Гэтэл энд хүүхдийн тоо ихсэх тусам итгэлцүүр нь буураад байгаа байхгүй юу. Энийг ер нь хэн ингэж гаргасан юм, энийгээ тайлбарлаж өгмөөр байна? Тэгээд 3500-аас дээш хүүхэдтэй сургуулийн итгэлцүүр 0.79 байсан нь 149 дүгээр тогтоол гэгчээр 0.72 болоод бүр буурчихсан доошоогоо. Хүүхэд олон болох тусмаа яагаад энэ итгэлцүүр буураад байна, энийг хэн нь тайлбарлах вэ надад?

Олон хүүхэдтэй тусмаа итгэлцүүр өндөр байгаад тэр хувьсах зардал өндөр байхгүй юм уу? Ачаалал нь их болох тусмаа өндөр байхгүй юм уу, ачаалал их болох тусмаа итгэлцүүр нь буураад, мөнгө нь багасаад байгаа байхгүй юу. Ийм нэг муухай зальжин аргаар сургуулиудын энэ хувьсах зардлаас цөлмөөд сууж байгаа шүү дээ. Энэ дээгүүр бодлого хийж байгаа та нарын л алдаатай, энэ санаатайгаар хийж байгаа шүү дээ энэ төрийн сургуулийн эсрэг хийж байгаа гэмт хэрэг шүү дээ ер нь. Хүүхдийн тоо олон болох тусам итгэлцүүр нэмэгдэх ёстой миний бодлоор. Энэ их ачаалал нэмэгдэх тусам энэ итгэлцүүр нь буураад, мөнгө нь багасаад байгаа байхгүй юу. Зүгээр нэг сургууль дээр 20-оос 30 саяар бараг буурч байсан ийм тооцоо байсан шүү.

Тэгээд сая Баасанжаргал гишүүний асуусантай агаар нэг асуулт байна. Төрийн хэт ачаалалтай сургуульд 0.72-оор өгчхөөд, хувийн сургуулийн орон зайд яагаад 2 дахин санхүүжилт олгох гэж байна вэ? Түрүүн асуулаа шүү дээ, хувийн сургууль руу бас ингээд санхүүжилт. Төсвийн тодотголд сургуулийн хүртээмж, ачааллын асуудлыг шийдэхийн тулд хувийн 3 сургуулийн сул орон зайд 1090 хүүхэд суралцуулж, хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлэн олгоход 2.4 тэрбум төгрөг төсөвлөжээ. Энэ мөнгөө яагаад тэр улсын сургуулиуд, төрийн сургуулиуддаа өгөхгүй байгаа юм, яагаад заавал хувийн сургуулиудад ингэж өгөөд байгаа юм бэ? Ингээд хувийн сургуулиудыг тэтгээд хэдэн монопол, хэдэн баяжсан гарууд нь улам баяжаад, төрийн сургуулийн нөгөө жирийн иргэдийн хүүхдийн нөгөө төрийн сургууль, төрийн багш нар бүгд.../минут дуусав/

О.Номинчимэг: Мөнхтуяа гишүүн нэмэлт нэг минут.

Ц.Мөнхтуяа: Ингээд кастын системийг төр нь өөрөө үүсгээд байдаг. Бүр баян ядуугийн ялгаа гарчихсан шүү дээ Монголд. Та нар тэр СХД-ийн хамгийн захын сургуулиар очоод үзээрэй, тэгээд тэр хувийн нэг хэдэн 30, 40 саяын төлбөртэй том сургуулиудаар нэг ороод үзээрэй. Кастын систем чинь ингэж үйлчилж байгаа Монголын нийгэмд, тэгээд энийгээ ярихгүй. Тэгээд төрийн сургуулиа хаяад, хувийн сургууль руу баахан хувьсах зардал нэртэй мөнгө өгөөд байгаа. Энэ асуудлыг яг энэ сайд нь байвал асуумаар байх юм. Тэгээд нэг хүн ирчхээд би мэдэхгүй, би мэдээгүй, би цээжлээгүй гээд суугаад байх юм. 1800-аас дээш хүүхэдтэй сургуулийн

итгэлцүүрийг ядаж нэг хувь болгоход хэдэн төгрөг шаардлагатай вэ? Боловсролын яам энэ дээр бодлого, тоо байна уу? 1800-аас дээш хүүхэдтэй төрийн сургуулийн итгэлцүүрийг 0.91-ээс 0.72 болгон бууруулахын оронд.../минут дуусав/

О.Номинчимэг: Мөнхтуяа гишүүний итгэлцүүртэй холбоотой асуултад 5 номер уу? 5 номер хариулья.

А.Мөнх-Оргил: Боловсролын яам Мөнх-Оргил гишүүний асуултад хариулья. 1 дүгээрт, тэр хувьсах зардлын итгэлцүүрийн талаар. Хувьсах зардал гэдэг нэг хүүхдийг тооцож байгаа өртөг, итгэлцүүр гэдэг нь тухайн сургуулиудад байх ёстой яг тухайн хүүхдүүдэд чанартай багш нь байгаад, орчин нь байгаад, сургалтын хэрэглэгдэхүүн байгаад олгох ёстой мөнгийг тооцдог тохируулга юм. Тэгэхээр хэдийгээр хүүхэд нь их байх тусмаа нөгөө хүүхдэд ногдох зардал нь буурч байгаа. Яагаад гэвэл хувьсах зардлыг тооцохдоо сургалтын хөтөлбөр, тэрэн дээр суурилсан хэдэн багш ажиллах вэ гэдэг тооцоон дээр үндэслэж хувьсах зардал гардаг. Тэгэхээр хэдийгээр итгэлцүүр ашиглаж байгаа ч гэсэн хэрвээ тухайн сургуулиуд хүүхдийн тоо өндөртэй бол төсөв өндөр байдаг, хүүхдийн тоо бага байвал төсөв бага байдаг. Хэрвээ бүх итгэлцүүр байхгүй, хувьсах зардал нэг ижил дүнгээр тооцоод олгох юм бол тухайн сургуульд ажиллах шаардлагатай сургалтын хөтөлбөрөөр байх ёстой багш нар, бусад үйлчилгээний зардлаас тухайн төсөв илүү гарна, угаасаа илүү гарна гэсэн үг. Тийм учраас хувьсах зардлыг тогтворжуулаад, тэнцвэржүүлж байгаа зүйл нь итгэлцүүр. Түүнээс яг тухайн хүүхдэд очиж байгаа сургалтын үйлчилгээ байх ёстой багш, хичээл заах ёстой хэрэглэгдэхүүн бүх юм ижил тэгш очиход энэ хувьсах зардалд нөлөөлж байдаг.

2 дугаарт нь, тэр хувьсах зардлыг 2 дахин өгч байгаа бол гуравхан сургууль байгаа, яг гэрээ хийчихсэн байгаа нэг л сургууль байна. Энэ яагаад ингэж байгаа вэ гэхээр үнэхээр тухайн орчинд хүүхэд сурах сургууль байхгүй учраас түр хугацаанд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ. Тухайн хувийн сургууль бүх сургалтын орчныг төрийн сургуультай адилхан бүрдүүлээд, бүх үйлчилгээг чанарын шаардлага хангасан хүрээнд хүргэхэд шаардлагатай учраас хувьсах зардлыг тодорхой хэмжээгээр өсгөж өгч байгаа. Энэ нь 1-ээс 2 жил үргэлжлээд дуусна гэж бид нар төлөвлөж байгаа.

Сургалтын төлбөр хэдийгээр таны хэлж байгаа зөв, үнэхээр хувийн сургуулиудыг төрийн сургуулиудыг ижилхэн байх ёстой. Гэхдээ нөгөө талаас Үндсэн хуулиар бүх хүүхэд сурах ёстой учраас бид нар суурь хувьсах зардлыг өгөх ёстой. Өгөхдөө өндөр төлбөртэй сургуулиудад төлбөрийнх нь хэмжээтэй уялдуулаад итгэлцүүрээр өгөөд, өөрөөр хэлбэл өндөр төлбөртэй 10 саяас дээш байх юм бол авахгүй ч гэдэг юм уу ийм зохицуулалтыг хийдэг. Би түрүүний асуулт дээрээ нэмээд хариулчих уу?

О.Номинчимэг: Яах вэ, Мөнхтуяа гишүүн хариулья, нэмэлтээр асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Үндсэн хуульд ЕБС үнэгүй, төлбөргүй байх ёстой. Харин ч хуулиа зөрчиж байгаа, баахан хувийн сургууль борооны дараах мөөг шиг болсон, болоогүй нэг баахан хувийн сургууль, мөнгө авахаас өөр тэнд сайн сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа чанарыг шалгах юм бол тэг сургуулиуд зөндөө байгаа. Уншиж, бичиж чадахгүй 5 дугаар ангийн хүүхдүүд улсын сургууль руу орж ирдэг шүү, би энийг бүр нотлох баримттай ярьж чадна. Ийм хачин балай юм битгий ярьж хүний ам таглаад бай та нар. Тэгээд тэр итгэлцүүр ингээд Энх-Амгалан сайдын үед нэг

байсан шүү дээ. Тэгээд Наранбаярын үед энэ чинь ингээд буураад 0.72 хүртлээ буурсан, энэ дээрээс 28 хувийн санхүүгийн төсвийн ингээд буурч байгаа байхгүй юу нэг сургууль дээр, та нар энийгээ тооцож үзсэн юм уу? Энийг чинь ингээд сургуулийн захирлууд эд нар надад ирж хэлдэг юм шүү дээ. Та нар намайг нэг юу ч мэдэхгүй тэнэг юм энд ингээд буруу, зөв яриад сууж байна гэж бодож байна уу? Би энд чинь тооцоо баримттай.../минут дуусав/

О.Номинчимэг: Сайдаас, энэ төсвийн хэлэлцүүлэг угаасаа өнөөдрөөр дуусахгүй. Энэ чинь төсөв 25 өдөр хэлэлцэгдэнэ цаглавраараа, 10 сарын сүүл хүртэл ямар ч байсан хэлэлцэгдээд ажлын хэсэг гараад явах байх. Тэгээд урьд нь ч гэсэн ингээд Энх-Амгалан сайд ч гэсэн өөрийнх нь бодлого нь энэ хувийн сургууль, улсын сургуулийн тэгш бус байдлыг арилгах энэ тал дээр анхаарч бодлогоо гаргаж байгаа гэж бид нар ойлгож байгаа, олон нийтэд өгч байгаа мэдээлэл нь ч гэсэн тийм байгаа. Өмнө нь төсвийн тодотголоор ингээд ААН-үүдийн нэг хувийн татвараар төр авахгүй, шууд хувийн сургуулиудад өгч болохоор, бүтээн байгуулалтад зарахаар ийм бодлого орж ирж байсан, болохгүй, энэ өөрөө нийгмийн хуваагдал, Мөнхтуяа гишүүний хэлж байгаа энэ ялгаатай байдлын үндэс болоод байгаа юмыг бид нар ерөөсөө өөгшүүлж, бодлогоор өөгшүүлж болохгүй гээд энийг УИХ таслан зогсоож байсан. Тэгээд би сайд нь ийм бодлоготой байгаад байдаг, УИХ ч гэсэн ийм чиглэл рүүгээ бодлого дээр ийм шийдлүүд гаргаад байхад ийм байгаа дээр нэлээн төсөв дээр энэ асуудал хэлэлцэгдээд явах байлгүй, боловсролын салбарын хөрөнгө оруулалт дээр. Яамныхан болон Сангийн яам энийгээ анхааралдаа авна биз. Тэгээд Хүний хөгжлийн байнгын хороон дээр ч гэсэн нарийвчилж яригдах зүйлүүд байдаг байх гэж харж байна, мэргэжлийн Байнгын хороо. Ундрам гишүүний нэрийг хасчихъя, чөлөө аваад гарсан учраас. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу. Бид нар нөгөө тодотголыг ойлгож ярилцахын тулд өнгөрсөн жил юу болсон бэ гэдгээ харах хэрэгтэй болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр өнгөрсөн жил 26 оны Засгийн газрын төлөвлөгөөнд ингэж төлөвлөсөн байна л даа. Төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжийг хангах нь гэсэн байгаа. Тэгээд шалгуур үзүүлэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулсан квотыг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагын тоо шинээр тооцох юм байна. Тэгээд тооцоод 26 оны зорилтот түвшин 10 хувиар нэмэгдүүлнэ гэсэн байна. Энэ 10 хувийг надад мэдээлэл бэлдээрэй, Сангийн яам.

2 дугаарт нь, татварын бодлогоор дамжуулаад энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэсэн байгаа юм, 24.1.3 дээр. Шалгуур үзүүлэлт нь орчин нөхцөлийг бүрдүүлж, хуулиар олгогдсон татварын хөнгөлөлтөд хамрагдсан ААНБ, иргэний өсөлтийг мөн 26 онд шинээр тооцно гэжээ. Тэгээд зорилтот түвшин 5 хувиар нэмэгдүүлнэ гэсэн байгаа юм. Тооцоод байгаа түвшнээс нь 5 хувь нэмэгдүүлнэ гэжээ. Үүнийх нь үр дүнг харж байж бид нар нөгөө дараа жилийн төсөв төлөвлөгөөг ярих хэрэгтэй болох гээд байна. Ойлгох хэрэгтэй болох гээд байна.

Бас нэг тодруулмаар байгаа зүйл нь, нийгмийн халамжийн зорилтот бүлэгт чиглүүлнэ гэсэн байгаа, 26 онд зорилтот бүлэгт чиглүүлнэ гэж байгаа юм. Зорилтот бүлэгт чиглүүлэхдээ нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дундаж болон амьжиргааны түвшний харьцаа бүсээр энийг нь тооцно гэсэн байна лээ. Тэгэхээр би Гэр бүлийн яамнаас болон Сангийн яамнаас аль алинаас нь асууя л даа. Яг одоогоор халамжийн мөнгө, асаргааны мөнгө, улиралд авдаг эм зэрэг энэ

халамжийн мөнгөн бүтээгдэхүүнүүд байгаа. Эдгээрийн яг дүн тоо яг одоо хэдэн төгрөг байгаа юм? Тэгээд тэрийгээ инфляцтайгаа харьцуулаад ер нь яаж өсөлтөд, эд нар ер нь үнэ өртөг нь яаж өөрчлөх тухай тооцоонуудыг нь хэлмээр байгаа юм. Дахиад нэмэгдээд ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хэдэн хүн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдарч байна вэ яг одоогоор? Яагаад би эдгээрийг асуугаад байгаа гэхээр над дээр ирээд байдаг асуудал л байгаа юм л даа. Тэгэхээр энэ асуултуудыг Сангийн яам, Гэр бүлийн яам бэлдэнэ.

Эргээд хөдөлмөр эрхлэлт рүүгээ орёе. Улсын төсвийн энэ 25, 26 оны, 26 оны баталсан болон тодотголыг харахаар хэд хэдэн зөрүүтэй тоонууд харагдаж байна л даа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвийн зардал болохоор ингээд 60 саяар буурчихсан байна. Гэтэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт гээд 32 саяар нэмэгдээд, нөгөө баталснаасаа тодотгоод одоо энэ чинь он нь дуусаагүй байгаа шүү дээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан мөн 392 сая аравны таваар нэмэгдчихсэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв мөн нэмэгдчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм олон ийм ижил төстэй нэртэй байгууллагуудын төсөв хэдэн зуун саяараа нэмэгдээд байхад яагаад өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилд орж чадахгүй байгаа юм бэ? Яагаад ААНБ тэр хүмүүсийг ажилд авч чадахгүй байгаа юм бэ? Тэгээд уул нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 хүн тутмын 6, 7 нь ээжээсээ эрүүл төрчхөөд осол гэмтэл, өвчнөөс болж бэрхшээлтэй болоод байгаа шүү дээ. Бид нар тэр хүмүүсээ сэргээгээд авчихвал энэ чинь уул нь нийгмийн капитал мөн байхгүй юу. Тэгэхээр тэд нарыг сэргээж авъя гэхээр байна шүү дээ улсын төсвийг харахаар сэргээн засалтын чиглэлийн зардлууд нь ингээд хасагдчихдаг, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх зардлууд нь ингээд хасагдчихдаг. Энэ дээр ер нь ямар бодлого байна вэ гэдэг дээр Гэр бүлийн яамнаас яг тодорхой хариулт авмаар байна.

Тэгээд би асуусан байгаа, Хөдөлмөрийн тухай хуулийн тэр 144 гээд байгаа заалтын хэрэгжилт яасан бэ? Тэрийгээ бүр нэмээд тодорхой хариулчих. Тэгээд би дараа нь тодруулъя.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүний асуултад Гэр бүлийн яам, Төрийн нарийн бичгийн дарга хэдэн номер дээр байна, наашаа ирээрэй. Төрийн нарийн бичгийн дарга Даваажаргал, хурдан суучхаарай. Гэр бүлийн яамнаас асууж байхад микрофон дээр 1 номер уу, 1 номер. Нэрээ хэлээд гишүүний асуултад хариулъя.

А.Даваажаргал: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ТНБД Даваажаргал. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллын асуудал дээр тодотголоор ямар нэгэн төсөв хасагдаж, танагдаагүй байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар дээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан ажилладаг, энэ нь жилийн 15.9 тэрбум төгрөгийн төсөвтэй. Энэ сангийн үндсэн үйл ажиллагаа бол хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бэлтгэх ажлыг зохион байгуулдаг. 26 оны эхний хагас жилийн байдлаар 300 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэлтэд зохион байгуулж ажилласан гэдэг ийм тоон мэдээллийг өгсөн.

Татварын бодлогоор дэмжиж байгаатай холбоотой асуудал энэ ХХОАТ-ын тухай хууль дээр ХХОАТ-аас чөлөөлөгддөг субъектүүд дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хувь хүний орлогын албан, хувь хүний орлого албан татвараас чөлөөлөгдөхөөр зохицуулалтууд хийгдсэн байгаа. Нийгмийн халамжийн зорилтот

бүлгийг тодорхойлж байгаа энэ журамд бид нар нэлээн өөрчлөлт оруулсан, энэ журамд өөрчлөлт орсонтой холбоотойгоор халамжийн сангийн зардлууд нэлээн хэмнэлт гарсан. Салбарын төсвөөс, Нийгмийн халамжийн сангаас нийтдээ 42 тэрбум төгрөгийг бид нар тодотголоор хасуулж байгаа, шалтгаан нь энэ зорилтот бүлгийн халамжийг зөв тодорхойлдог, халамжийн санхүүжилтийг олгохдоо зөв механизмаар олгож байгаатай холбоотойгоор хэмнэлт гарсан. Энэ хэмнэлтээс үүдэлтэйгээр 44.2 тэрбум төгрөгийн санхүүжилт тодотголоор хасагдаж байгаа. Тэрнээс хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, хүний асуудалтай холбоотойгоор ямар нэгэн төсөв санхүүжилт хасагдаагүй байгаа.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Сэргээн засах, туслах технологийн төвийн зардал нь ингээд хасагдчихсан л байгаад байгаа юм, энэ би нөгөө цаасан цагаан дээр биччихсэн файлыг хараад яриад байгаа шүү, энийг тодруулмаар байна. Дахиад асуучихъя, Сангийн яамнаас. Тэгээд хэдэн төрийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах квотоо бүрэн биелүүлсэн юм бэ? Хэдэн ААН хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд авсан квотоо биелүүлсэн юм бэ? Энэ суурь дүнгээс зорилтот түвшин энэ гэдэг нөгөө тайлангаа бид нар харж байж дараа жилийн төсвийн зарцуулалтаа ярих гээд байгаа учраас л би асуугаад байгаа байхгүй юу.

Дахиад асуучихъя, халамжийн мөнгө хэдийг авч байгаа вэ? Асаргааны мөнгө одоо яг хэд байгаа вэ? Бүс бүсээр өөр байгаа юу? Улирал болгонд нөгөө эмийн хөнгөлөлт гээд Ерөнхий сайдын эмээ хүн авахын тулд амар болно гээд байгаа шүү дээ, тэр хөнгөлөлтөд ямар, ямар эмүүд орж ирж байгаа юм? Тэр эмийн жагсаалтыг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой хэрэглэдэг эмүүд тэр бүлэгт байгаа юу, үгүй юу? Тэр мэдээллийг тодруулмаар байна, 3 асуулт.

О.Номинчимэг: 1 номер асуултад хариулъя.

А.Даваажаргал: Яг Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн дундаж 450 орчим мянган төгрөг байгаа. Залуу насандаа ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй хүмүүс Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэрт гарч байгаа, энэ 432 мянган төгрөгөөр тогтоогдсон. Асаргааны тэтгэмж 478 мянга орчим төгрөгөөр дунджаар байгаа. Нийгмийн халамжийн тухай хууль дээр эдгээр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогтоохдоо амьжиргааны доод түвшинтэй уялдуулан тогтооно гэдэг ийм хуулийн зохицуулалттай. Яг амьжиргааны доод түвшнийг ҮСХ гаргадаг, яг албан ёсоор манай байгууллагад ҮСХ-ноос амьжиргааны доод түвшнийг тогтоож ирүүлсэн тоон мэдээллүүд байхгүй байгаа. Яамны эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын төсвөөс нэмэгдсэн төсөв байхгүй. Сая энэ оны 8 сарын 5-ны өдөр Засгийн газрын.../минут дуусав/

О.Номинчимэг: 1 номер гүйцээж хариулъя.

А.Даваажаргал: 325 дугаар тогтоолоор бүх төрийн байгууллагуудын цалингаас бусад зардлууд царцсан байдалтай байгаа. Энэтэй холбоотойгоор зарим нэг гүйлгээнүүд хийгдэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар дээр энэ дэмжих сангийн гүйлгээнүүд царцсан байдалтай байгаа, тэрнээс биш яг төсвийн тодотголоор юм уу ямар нэгэн байдлаар санхүүжилт татагдаагүй. Мөн төсвийн тодотголоор манай яамны төсөв дээр ямар нэгэн байдлаар нэмэлт орлого төвлөрүүлэхээр заагдаагүй. Ер нь яамны төсөв дээр нийтдээ 196 тэрбум төгрөг 11,

12 сарын суурь тэтгэвэр дээр орж ирсэн. Үүнээс бид нар татааснаас буюу өөрсдийнхөө хэмнэлтээр 47 тэрбум төгрөгийг нь гаргасан, үлдсэн тэр мөнгийг нь бусад эх үүсвэрээс Сангийн яамнаас тавьж өгч байгаа.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Ингээд нөгөө инфляцтай холбоотойгоор гээд байгаа шүү дээ, өөр баахан нийгэм, эдийн засгийн хямрал болоод байгаа. Тэгэхээр энэ хүмүүсийн авч байгаа энэ дүн мөнгө нь, би уул нь ингээд халамжийн мөн асаргааны мөнгө гэсэн ийм асуудлыг уул нь их бага болгоомжтой ярих ийм бодолтой байдаг. Гэтэл яг өнөөдөр амьдрал дээр мөнгөн бус үйлчилгээ нь өөрөө баялаг биш байна л даа. Хүмүүсийг хөл дээр нь босгодог үйлчилгээ Монголд байхгүй байна шүү дээ ерөөсөө, бэртэж гэмтээд чи энэ халамжийг аваад тэгээд ингээд бай гэдэг маягтай.

Тэгээд ажилд оруулаад байгаа юм уу гэхээр ажилд ороогүй хүмүүс байгаад, орсон нэр зүүгээд байгаа юм уу, юу юм гэдэг нь үр дүн байхгүй. Тэгэхээр энэ нэгэнт мөнгөн бус үйлчилгээгээ олигтой үзүүлж чадахгүй юм бол төрөлжүүлж чадахгүй юм бол энэ мөнгөн энэ халамжийнхаа дүнг энэ хүн ам чинь ингээд орхигдлоо шүү дээ. Энэ шуурган дунд орхигдох гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр тооцоолол, санал энэ тэр Гэр бүлийн яам энэ тэр гаргадаггүй юм уу энэ хүн амынхаа асуудлаар? Халамж, асаргаа авч байгаа хүмүүс чинь бараг байхгүй болох нь байна шүү дээ.

О.Номинчимэг: 1 номер.

А.Даваажаргал: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ намрын чуулганаар Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэл ажлыг хангаад өргөн барьсан байгаа.

2 дугаарт нь бид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг ажлын хэсэг одоо үзэл баримтлалыг батлуулах шатандаа явж байгаа. Ер нь нийгмийн халамжийн асуудал дээр ЗГ-аас ямар байр суурь барьж байгаа вэ гэхээр халамж авч байгаа иргэнд нөлөөлөх байдлыг илүүд үзэж байгаа. Тэрнээс биш халамж авч байгаа иргэнд санхүүжилт тараагаад байх нь өөрөө халамжаасаа татгалзах үндэслэл болохгүй байна. Ямар ч хүн халамж аваад байгаа тохиолдолд халамжаасаа хөдөлмөр эрхлэлт рүү шилжихгүй байна. Харин тэр халамж авч байгаа иргэнд гуравдагч хүчин зүйлээр нөлөөлөх байдлаар халамжаас нь татгалзуулах, хөдөлмөр эрхлэлт рүү шилжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Амьжиргааны доод түвшинтэй уялдуулж энэ тогтоож байгаа нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг бид нар байнга уялдуулаад яваад байх ер нь төр дийлэхгүй. Амьжиргааны доод түвшин байнга өөрчлөгдөнө, тэр болгонд нь.../минут дуусав/

О.Номинчимэг: Яагаад болохгүй байна гэдэг асуултад нэмэлтээр хариулаадхаач. 1 номер.

А.Даваажаргал: Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг одоогийн байгаа хууль дээр, Нийгмийн халамжийн хууль дээр амьжиргааны доод түвшин ҮСХ-ноос тогтоосон, тэр тогтоосон хэмжээтэй уялдуулна гэдэг л зохицуулалт байгаад байгаа, яг адилтгаж үзнэ гэсэн зохицуулалт байхгүй. Хамгийн сүүлд 2022 онд тогтоосон, үүнээс хойш өөрчлөгдөөгүй байгаа. Яг олгогдож байгаа санхүүжилт хүний ажил амьдралд хүрч байгаа хүртээмжтэй биш байгаа гэдэгтэй би санал нэг байгаа. Гэхдээ

бид нар арга барилыг нь өөрчлөхгүй бол байнга санхүүжилт өгөх байдлаар халамжтай тэмцэнэ гэдэг өөрөө өрөөсгөл ойлголт, дэлхий нийтээрээ угаасаа хоцрогдсон ойлголт байгаа учраас бид нар өөр арга замаар шийдвэрлэхээр хуулийн төслүүдийг нь оруулж ирээд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байгаа.

О.Номинчимэг: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Төсөв улсын хөгжлийг л урагш татах гол чухал зүйл. Тэгээд улс орны хөгжил хүний хөгжлөөс хамаарна, хүний хөгжил нь чанартай боловсролоос хамаарна. Тэгэхээр төсөв дээр нэг номерт энэ боловсролд оруулах хөрөнгө оруулалт, энэ хамгийн чухал. Тэгээд энэ боловсролд орж байгаа хөрөнгө оруулалтыг энэ төсвийн тодотголоос ингээд харж байхад нэмж байна, хасаж байна. Тэгээд энэтэй холбоотой би энэ Аудитын газраас дүгнэлтийг нь сонсьё гэж бодож байна л даа. Ямар хүчин зүйлээс болж энэ тодотгол хийх болов? Ямар хүчин зүйл энд тодотгол болсон, ингээд төсөв хийчхээд л тэгээд нэг тодотгож байдаг. Жил болгон л энэ нь явж байна. Тэгэхээр эхнээсээ ингээд нарийн тооцоолоод энд ямар алдаа гарав? Өнгөрсөн жилийн төсөв дээр 26 онд батлахад. Тэгээд энэ удаагийн нэмэлт, өөрчлөлт, тодотгол үр дүнтэй болж чадсан уу гэдгийг Аудитын газраас асууя.

Ер нь тэгээд бид энэ төрийн сургуулиудын үүсгэн байгуулагч нь төр өөрөө байгаа. Ингээд л төрийн өмчийн сургуулиуд чанаргүй байгаад байхаар хувийн сургуулиуд нэмэгдээд байна. Тэгээд тэр хувийн сургуулиуд руу нь юу нь явж, сая яамны тайлбар гарч байна шүү дээ, төрийн сургууль нь хүрэлцэхгүй байгаа учраас бид нар арга ядаад хувийн сургуультай ийм төр гэрээ хийгээд ингээд орж байгаа гэж байна. Тэгвэл бид нар энэ төр хүнээ хөгжүүлэх энэ тал дээр, ирээдүй болсон хүүхдүүддээ анхаарах тал дээр, чанартай боловсрол олгох тал дээр бид нар энэ хариуцлага хүлээх ёстой, энэтэй холбоотой асуултууд асууя.

Баасанжаргал гишүүнтэй асуудал давхцаж байгаа байна. Тодотголд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд 50 тэрбум нэмж оруулж байна, тэгээд энэ нь ингээд энэ зардал нь хотхоны бага сургууль, тэр гэрт ойрхон сургууль гэж нэрлээд байгаа тэр төрөлжсөн ахлах сургуультай холбоотой байна. Тэгээд цэцэрлэгийн схемээр хотхоны бага сургуулийг шийдэж байгаа гэж, энэ тэгээд зөв шийдэл юм уу? Цэцэрлэг нэг ангид хүүхдийг бага ангийг ингээд оруулаад суулгачхаж болж байна, бага сургуулийн, сургуулийн стандарт гэж байна уу, энд мөрдөгдөж байгаа юу гээд түрээсээр явдаг олон сургууль байдаг. Тэгээд энэ түрээсээр байдаг сургуулиуд дээр очихоор ерөөсөө л ганц л юм хүсдэг шүү дээ. Энэ түрээсийн стандарт бус энэ байрнаас бид нарыг чөлөөлөөд өгөөч, бид нарт өргөтгөл бариад өгөөч, ийм стандартгүй ийм газар бид нар энэ цонхгүй, тэгээд самбарынх нь өмнө багана нь ингээд гарчихсан, коридор нь алхаж болохгүй, ийм агааржуулалт муутай ийм газар бид нар баймааргүй байна, биеийн тамирын талбай алга, цайны газар алга, хүүхдэд ямар ч талбай орчин байхгүй байна. Энэнээс чөлөөлөөд өгөөч гэхэд бид нэмээд ингээд явах нь байна шүү дээ, энэ маань. Тэгэхээр энэ шинэчлэл мөн юм уу гэдгийг нэг асууя.

Сангийн яамнаас би бас асуумаар байгаад байгаа юм, би нэлээн тооцоо хийж өгсөн л дөө. Нэг бүлэгт байх хүүхдийн тоо 40-өөс доош оруулъя гэдэг KPI бид нар гаргасан, энийг Боловсролын яам 35-аас доош болгоё гэдэг гоё өөдрөг юу гаргасан л даа, тэгээд одоо энэнээс дээш би 35-аас дээш нь бодоод үзэхээр 9200 бүлэг, 1800-аас дээш хүүхэдтэй сургуулийг бид нар задалъя гээд ингээд үзэхээр 127 сургууль,

370 мянган хүүхэд буюу нийт суралцагчдын маань 50 хувь сураад байна. Энд ямар ч чанартай боловсрол олж авах тийм асуудал яригдахгүй. Чанартай боловсрол авч чадахгүй байна гэдгийг нь ингээд харсаар байж бид нар энэний цогц шийдлийг хийхгүй, энэ амиа бодсон аргацаасан ийм шийдэл хийгээд байх нь зөв юм уу гэдгийг, энэ дээр бид өмнө нь ярьж байсан 108 сургууль, 95 цэцэрлэгийн асуудал тэр хэр явагдаж байгаа вэ? Энэ нэг KPI шалгуур тавиад яваад байсан энэ юм энэ жилийн саяын төсвийн тодотгол дотор ч гэдэг юм уу ингээд хэр тусаж байгаа вэ гэдгийг асууя?

Боловсролын яамнаас ахиад нэмээд асуухад, багшийн хомсдол өнгөрсөн 6 сард сайт дээрээс нь харахад 3957 гэж байсан юм. Сая хичээлийн жил эхлээд ер нь хэдэн багш дутагдаж байна вэ? Тэрийг нэг хэлээд өгөөч, тэгээд тодотгоё.

О.Номинчимэг: Үндэсний аудитын газар, Боловсролын яам, Сангийн яам бэлдээрэй. Үндэсний аудитын газар, Цэдэнжав аудиторын орлогч ирсэн байгаа юу? 4 номер. Аудитын газраас асуусан Галбадрах гишүүний асуултад хариулъя. Боловсрол, Сангийн яам юун дээр микрофонд сууж байгаарай, 4 номер.

3.Цэдэнжав: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар, Ерөнхий аудиторын орлогч Цэдэнжав. Төрийн аудитын байгууллага Засгийн газраас өргөн барьсан 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлтээ гаргаж, УИХ-д хугацаандаа хүргүүлсэн байгаа. Энэ удаагийн төсвийн тодотгол хийх шаардлага бол Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн нөхцөлүүдтэй нийцсэн байна гэж үзсэн. Төсвийн тодотголыг хийхэд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн 4 тусгай шаардлагыг бол хангаж ажиллах ёстой, төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр бол тусгай шаардлагуудаас нэг шаардлагыг бол хангаагүй байсан.

Засгийн газар төсвийн тодотголыг өргөн барихдаа Төсвийн хүрээний мэдэгдэл болон дунд хугацааны төсвийн төсөөллийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах байдлаар бол энэ тодотголыг оруулж ирсэн байгаа. Монгол Улсын хэмжээнд нүүрсний экспорт нэмэгдсэн, уул уурхайн салбарын өсөлт харьцангуй тогтвортой байгаа боловч төсвийн тодотголыг хийх энэ шалтгааны хувьд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, зарлагын хэмжээ энэ тодорхой алдагдалтай байхаар бол ингэж оруулж ирж өгсөн байна лээ. Гол нь энэ ахмад настны орлогыг дэмжих, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн зөрүүг арилгах, хүнс, эрчим хүчний нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангахад ч гэсэн санхүүжүүлэхэд төлөвлөсөн байсан. Энэ нь бол нийгэм, эдийн засгийн эерэг үр нөлөөтэй боловч нэгдсэн төсвийн тэнцвэржсэн орлогыг нэмэгдүүлэхгүйгээр нийт зарлагыг 998 тэрбум төгрөгөөр өсгөж, төсвийн алдагдлыг 2 их наяд 48 төгрөг буюу ДНБ-ий 2 хувьд хүрэхээр байгаа нь төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй тохиолдолд төсвийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй эрсдэл гэж бид дүгнэсэн байгаа.

О.Номинчимэг: Тооцоолол хийсэн үү гэж 4 номер.

3.Цэдэнжав: Төрийн аудитын байгууллагаас энэ удаагийн төсвийн тодотгол болон өмнө Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг УИХ-аар хэлэлцүүлэхэд хийдэг аудит болон бусад энэ төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитаар энэ төсвийн тодотголыг хийх энэ үед төсвийн хүрээний мэдэгдлийг байнга өөрчилж байна, энийг бол тогтвортой байлгах шаардлагатай гэдэг дүгнэлтүүдийг бид байнга Засгийн газар, зөвлөмжийг бол өгч байсан.

О.Номинчимэг: Боловсролын яам суугаарай, 1 номер Сангийн яам хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя, Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр боловсролын яг барилга байгууламжийн хувьд бид нар 2 төрлийн байдлаар хэрэгцээг гаргаж байгаа. 1 дүгээрт нь яг улсын хэмжээнд ээлжийн коэффициент 2-оос дээш ээлжийн коэффициенттой сургууль 108 гэдэг сургууль тоог бид өмнөх онуудад гарсан, энэ тоо одоо яг улсын хэмжээнд явж байгаа сургуулиудын хүрээнд 86 болсон байгаа. Цэцэрлэгийн хувьд яг нэг ээлжээс дээшээ коэффициенттой буюу энэ улсын хэмжээнд 95 байршил байгаа, энэ болохлоор 84 болсон, тэгэхээр 27 оныг яг энэ 86, 84-ийг ахиад бууруулах хэмжээнд нь ингээд төлөвлөж байгаа. Нөгөө төрлийн хэрэгцээ маш эртний барилга байгууламжууд буюу ашиглалтын шаардлага хангахгүй, нураах эрсдэлд орчихсон, гэхдээ ээлжийн коэффициент дээр нь харвал бага ээлжийн коэффициенттой боловч яг хүүхэд сурах орчин хангагдахгүй байгаа ийм, тэгэхээр 2 төрлөөр яг барилга байгууламжийн төлөвлөлтийг хийгдээд явж байгаа өмнөх жилүүдээс.../минут дуусав/

О.Номинчимэг: 1 номер гүйцээж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Өмнөх жилүүдээс ялгаа нь бид нар ганцхан улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна Нийслэл, орон нутаг, төр, хувийн хэвшлийн түншлэл, мөн татварын нэг хувь, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудын хүрээнд яг бүх эх үүсвэрүүдээ гаргаж тавьж байгаад яг улсын төсөвт дутагдаад байгаа эх үүсвэр дээрээ хөрөнгө оруулалт. 26 оны тодотголын хувьд яг Хэмнэлтийн тухай хуулиараа гэрээ байгуулаагүй төслүүд хэмнэлтэд орсон. Тэгэхээр 26 онд анх батлагдахдаа боловсролын салбарт 506 тэрбум байсан бол 24 тэрбумаар буураад, энэ нь яг гэрээ байгуулаагүй төслүүдийн хувьд хэмнэлтэд орсон, тэгээд энэ дээр 2 сургууль, 3 цэцэрлэг хэрэгжиж чадаагүй байгаа. Тэгээд эндээсээ бид нар яг эх үүсвэрээр нь эрэмбэлээд зарим нэгийг нь 27 он дээр буцаад яг иж бүрэн хэрэгжихээр нь төлөвлөж оруулж ирсэн байгаа.

О.Номинчимэг: Боловсролын яамнаас асуусан асуулт, 9 номер хариулъя.

А.Мөнх-Оргил: Боловсролын яам Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Ер нь мэдээж хүүхдийг сургалтын стандарт, шаардлага хангасан орчинд сургах хэрэгтэй. Энэний тулд яалт ч үгүй сая хэрэгжсэн энэ олон улсын болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа, ачаалал ихтэй байгаа байршлуудад сургуулийг оруулах хүртэл одоогоор энэ түрээсийн сургууль, цэцэрлэгийн арга хэмжээ түр арга хэмжээ байгаа. Бид 38 байршил дээр нийслэлд энэ хичээлийн жилд сургууль түрээслээд ажиллуулах гэж байна.

Багшийн хомсдолын мэдээллийг би дараа нь бичгээр өгье. Түрүүн тэр төрөлжсөн ахлах сургуулиудын тоног төхөөрөмжийн хувьд энэ дандаа их, дээд сургуулиудын ахлах лицей сургууль байгаа юм байна, миний түрүүн тайлбарладаг зөвхөн нөгөө 3 сургуулийн хувьсах зардал 2 дахин нэмэгдсэнтэй холбоотой санхүүжилт байгаа юм байна гэдэг тайлбар өгчихье.

О.Номинчимэг: Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Энэ чинь энэ жил түрээсээр явж байгаа сургуулиудыг яриад байгаа шүү дээ, бид нар чинь ирэх жил нэмэгдэх байх. Энэ 22 газар дээр 14 тэрбум төгрөг, энэ жилийн түрээсийн тодотгол яриад байна, тийм үү, 26 оныхыг. Тэгээд 27 онд хэд болж нэмэгдэх юм, 1 м² нь хэдэн төгрөг байгаа юм, надад энд тооцоолол байна л даа. Тэгээд Яармагт, сая би Сангийн яамнаас нэмээд асуучихъя. Тэр сургуулиуд ингээд багасаад бид нар 108 сургууль, 95 цэцэрлэг байж байгаад 86, 84 болоод багаслаа гээд, тэгээд энэний чинь үр дүнд нөгөө 40-өөс доошоо нэг бүлэг дэх хүүхэд орно л гэсэн зорилго явж байгаа шүү дээ улсынхаа хэмжээнд. Түүнээс байршлыг нь гаргачихсан хот дээр 33 газар чөлөөлүүлчихсэн энэ тэр гээд бид нар чинь нэлээн юм хамтраад хийгээд явсан байсан. Тэгвэл одоо энэ Яармаг яригдаад байна шүү дээ, Яармаг дээр ерөөсөө сургууль байхгүйгээс тэр хувийн сургуультай хамтарч ажиллах болсон гээд байна. Ирэх жилийн төсөв яриагүй ч гэсэн зүгээр ирэх жил Яармагт энэ төрийн сургууль төсөвлөгдсөн юм байна уу, шинээр тийм юм оруулж болох уу?

О.Номинчимэг: Сангийн яам хариулах юм уу, эхлээд боловсрол, 9 номер.

А.Мөнх-Оргил: Түрээсийн нэгж үнэ 1 м² нь 48 мянган төгрөг байгаа. Тэгээд энэ нь яг хууль, эрх зүйн баримт бичгээр тогтоосон хэмжээнээс хэтрээгүй байгаа түрээсийн барилга. Одоо 38 байршилд, цаашдаа Дэлхийн банк, АХБ болон улсын төсвийн барилгууд нэмэгдэхээр бид нар цаашид түрээсийн барилгуудын тоо хэмжээ буураад явна гэж төлөвлөж байгаа.

О.Номинчимэг: 1 номер Сангийн яам.

Ж.Дэлгэржаргал: Энэ 108 сургуулийн 84 нь яг Улаанбаатар хотод хэрэгцээтэй сургуулиуд байгаа. Тэгээд Улаанбаатар хотод хамгийн тулгамдаж байгаа асуудал нь газар чөлөөлөлтийн асуудал, тийм учраас ирэх жил яг 52 дугаар сургуулийн өргөтгөл, тэгээд зарим байршилд сургууль, цэцэрлэг газаргүй учраас бэлэн барилгуудыг худалдаж авах чиглэлээр бол төлөвлөлт туссан байна.

О.Номинчимэг: Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Сая яамны маань хүн, та бүхэн ч гэсэн сонслоо шүү дээ, 1 м² нь 48 мянган төгрөг гэж байна, сургуулийн барилгын нэг метр квадратын талбай шүү. Энэ хотын төвд 1 м² бид нар энэ орон сууц, үгүй ээ, оффис /office/ хэдээр түрээсэлдэг юм бэ, 50 мянга орчим байгаа биз дээ. Тэгэхээр сургуулийн барилгыг бид нар энэ 48-аар тэр Яармаг ч юм уу, Нисэх ч юм уу, ийшээ ингээд. Би тэр 34 дүгээр сургууль дээр очиж үзэж байсан, тэр стандартад нийцээгүй барилга 50 мянган төгрөгөөр түрээсэлсэн байсан, метр квадрат нь. Тэгэхээр энэ чинь өөрөө ингээд нөгөө инфляц болох юм биш үү? Инфляц чинь бид 13-аас цаашаа ингээд алдаад байна шүү дээ. Тэгээд барилгын үнийг хөөрөгдөж байгаа юм биш үү энэ дээр, түрээс ийм үнээр өгчихдөг, одоо энэнээс цааш 27 онд бүр их нэмэгдэх байх. Ер нь хэд болохыг нь яах вэ дараа төсөв орж ирэхээр асууя гэж бодож байгаа. Одоо энэ 26 оны тодотгол дээр л орж ирж байгаа нь ийм мөнгө байгаад байгаа, тэгэхээр энэ мөнгийг энэ хэвийн байгаа 48.../минут дуусав/

О.Номинчимэг: 9 номер, Боловсролын яам.

А.Мөнх-Оргил: Энэ хамтарсан тушаалаар баталсан энэ жишиг үнийн дээд хязгаарыг тогтоосон байдаг. Энэ дээр сая миний 48 гэдэг яг одоо байр түрээсэлж

байгаа 38 байршлын метр квадратын дундаж үнэ байгаа юм. Яг дээд хязгаарыг яаж тогтоосон бэ гэхээр Хан-Уул, Сүхбаатар, ЧД-т 57 мянга, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Налайх, Багахангай, Багануур дүүрэгт 50 мянган төгрөгөөр тогтоосон, энэ жишгийг хэтрүүлэхгүй түрээслээд явж байгаа.

О.Номинчимэг: Золжаргал гишүүн асуулт асууя, нэрийг нь оруулаарай.

Ж.Золжаргал: Төсвийн тодотголын төслийг дагалдаад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл орж ирсэн байна лээ. Тэрэн дээр урсгал зардал ДНБ-ий 30 хувиас ихгүй байх гэдэг заалтыг авч хасна гэсэн санал орж ирсэн байна лээ. Төсвийн тодотгол дээр миний харснаар урсгал зардал ДНБ-ий 24 хувь байсан. Тэгэхээр 30 хувь бол хэтрээгүй байгаа, 30 хувь хэтрээгүй байхад 30 хувь гэдэг заалтыг яагаад хасъя гэсэн юм дагуулж орж ирж байгаа юм бэ гэдэг нэг ийм асуулт байна?

Урсгал зардал нь 33 хувь болчихсон, болохгүй болчихжээ, Төсвийн тогтвортой байдлын хуулиа өөрчлөөд 30 хувийн хязгаарыг авч хаяя гэмээр санагдаад байгаа байхгүй юу. Гэтэл 24 хувь байхад яагаад 30 хувийг авч хаях гэж оруулж ирсэн юм бэ?

О.Номинчимэг: Төсвийн хязгаар, зардлын хязгаарыг байхгүй болгож байгаа энэ хууль, хэн хариулах вэ? Сангийн яам уу, Эдийн засгийн яам уу? Эдийн засаг, хөгжлийн яамны макро эдийн засгийн хүн байсан шүү дээ, адилхан суучих хамтдаа энэ чинь эдийн засагт үзүүлэх нөлөө эд нар чинь маш чухал байгаа учраас 9 номер уу, 9 номер нэрээ хэлээд хариулаарай.

О.Мягмардорж: Эдийн засаг, хөгжлийн яам, Макро эдийн засгийн бодлогын газрын хэлтсийн дарга Мягмардорж байна. Золжаргал гишүүний асуултад хариулъя. Бид нар болохоор сая оруулсан өөрчлөлтөөр болохоор 24 оноос өмнө хэрэглэж байсан уул уурхайн бус зардлын өсөлтөөр нийт зардлын өсөлтийг хязгаарлах ийм зохицуулалтыг эргүүлж оруулж ирсэн. Урсгал зардлын хэмжээ ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх заалтыг аваад, оронд нь яг нийт зардлынхаа өсөлтийг уул уурхайн бус салбарын өсөлтөөс ингээд бага байлгахгаар, нэг ёсондоо уул уурхай дагасан өсөлтийг хязгаарлахаар оруулж ирсэн. Нөгөө талдаа дахиад нэмээд нийт хөрөнгийн зардлын үзүүлэлтийг төсвийн хүрээний мэдэгдлийн 9 үзүүлэлтэд нэмэгдэж өгсөн. Яг энэ хөрөнгийн зардлын хэмжээнийхээ үзүүлэлтээр хөрөнгийн зардлаа өсгөөд, нөгөө талдаа урсгал зардлаа хязгаарлаад явна, ийм бодлогоор оруулж ирсэн байгаа.

О.Номинчимэг: Би гишүүний хувиар, тодруулах гэсэн үү, уучлаарай. Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Уул уурхайн бус эдийн засгийн өсөлтийн хувиас ихгүйгээр урсгал зардал өснө гэдгийг ойлгочихсон. Гэхдээ 30 хувийг яагаад хассан юм бэ гэдэг асуулт байгаа, 30 хувь юунд ч гай болохгүй байна шүү дээ. Урсгал зардлын хувь нь 24 хувь байгаад байдаг, тэгээд 30 хувийг яагаад байхгүй болгох гээд байгаа юм бэ? Уул уурхайн бус эдийн засгийн өсөлт нь байж л байна биз, 30 нь байж л байна биз. 30-ийг яагаад төсвийн тодотгол дагуулж оруулж ирж хасаж байгаа юм бэ?

О.Номинчимэг: 9 номер уу, 9 номер.

О.Мягмардорж: Тэр зохицуулалтыг болохоор яг өмнө нь мөрдөж байсан яг 24 оноос өмнө хэрэглэж байсан тусгай шаардлагыг буцааж сэргээсэн, бусдаар яг урсгал зардлын юуг байхгүй болгосноор урсгал зардлыг өсгөж байгаа гэсэн үг биш.

О.Номинчимэг: Золжаргал гишүүн дахин тодруулъя.

Ж.Золжаргал: Ямар ч байсан миний уншсан урсгал зардал 24 хувь байна гэдэг нь 24 аравны хэд ч билээ үнэн юм байна, 30 хувийг байхгүй болгож байгаа юм байна хязгаарыг. Тэгэхдээ 24 онд хуучин хуульд уул уурхайн бус өсөлтөөр хязгаарлагдана гэж байсан, 30 хувь гэж байгаагүй, хуучин заалтаа сэргээж байгаа юм гэдэг ийм л үндэслэл байгаа юм байна гэж ойлголоо, боллоо.

О.Номинчимэг: Төсвийн тодотгол дээр яахгүй байх, дараа нь 27 оны төсөв гээд цаашаагаа энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгч байгаа санал, дүгнэлтийг хараад явахад энэ нэлээн чухал асуудал болох байх гэж бодож байна. Би гишүүнийхээ хувиар 3 асуулт асуух гэсэн юм. Эхнийх нь Чингис хаан баялгийн сан ХХК-иас, ер нь манай Өргөдлийн байнгын хороон дээр сая хаврын чуулганы туршид энэ ахмадуудын тэтгэврийн асуудал нэлээн их тавигдсан. Тэгээд энэ итгэлцүүрийн асуудал, энэнээс болоод хохирсон олон жил ажилласан ахмадуудын асуудал, энийг шийдэж өгөөч гээд бид нар ажлын хэсэг гараад Гэр бүл, хөгжлийн яамтай нэлээн хамтарч ажиллаад, ингээд Засгийн газар ч гэсэн бодлогоо тодорхойлоод ийм шийдэл гаргаад хууль баталсан. Тэгээд энэ ахмадуудын энэ итгэлцүүрээс болоод тэгш бус, бага тэтгэвэр тогтоолгож байгаа асуудлыг шийдэх гээд орж ирж байгаад би хувь хүний хувьд дэмжиж байгаа. Ялангуяа энийг бол энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, өмчийн компанийн хууль гарсан, тэгээд өмнө нь энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниуд, ялангуяа томоохон байгалийн баялгийн лицензийг /license/ эзэмшиж байгаа энэ компаниудын төсөв хөрөнгө бол төсвөөс гадуур байгаад, төрийн хяналт байхгүй явж байсан байдлыг бага ч гэсэн нэг удаагийн жишиг гаргаж, тэтгэвэрт зарцуулах гээд орж ирж байгаад хувь хүний хувьд дэмжиж байгаа.

27 оны 1 сарын 1-нээс хууль хэрэгжээд эхэлнэ. Тэгэхээр яах вэ, энэ нөгөө бид байгалийн баялаг бусад иргэддээ хүртээмжтэй байх ёстой, одоо тулгамдаж байгаа энэ асуудлаа шийдэхэд энийг ноогдол ашгаасаа зарцуулах нь зөв гэж үзэж байгаа юм. Зүгээр нөгөө сөрөг тал нь, хэрвээ төр ямар нэгэн ноогдол ашгийн бодлого гаргахгүйгээр бүх бодлогоо, ноогдол ашгийг нь төсөв рүү татаж аваад байвал нөгөө компаниуд маань өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтыг дахиж хийх боломжгүй болоод, өрсөлдөх чадвар нь багасна гэсэн бас нэг юм байна. Мөн нэгэнт л ноогдол ашиг бүгдийг нь ийш тийшээ татаад авч байгаа юм чинь өөрөө ашигтай байх инсентив /incentive/ буюу өөрийн хөшүүрэг нь багасах гээд байдаг ийм хуультай, жамтай. Тэгэхээр энэнээс сэргийлсэн энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын менежмент, үр ашгийг нь дээшлүүлэх, дээр нь энэ хөрөнгө оруулалтыг нь яаж зохистой түвшинд хадгалж, дараа дараагийн өрсөлдөх чадварыг нь бусниулахгүйгээр байх уу гэдэг дээр энэ дээр ямар асуудлуудыг та бүхэн маань бодлогын хүрээнд харж байна вэ? Ноогдол ашгийн бодлого гэдэг юм салбар салбараар, компани компаниар гарч байна уу, яаж байна гэдэг дээр нэмэлт нэг асуултад хариулт авъя.

2 дугаарт, ЭХЯ-наас асууя. Манай иргэдийн хувьд одоо яг Өргөдлийн байнгын хороонд гаргаж байгаа нэлээн их юм ерөөсөө л амьжиргаатай холбоотой асуудал байгаа, үнийн өсөлт, инфляцаас хамаараад амьжиргаа доройтож байгаа

асуудал байгаа. Тэгээд тэрний нэг бол яах вэ, ингээд эрчим хүч, дулааны цахилгаан үнэ нэмэгдээд, дагаад энэ инфляц, суурь үнэ өссөнтэй холбоотой байгаа. Төсвийн тодотгол дээр яах вэ, энэ эрчим хүчний үнийг нэмэхгүй барихын тулд 107 тэрбум төгрөгийн татаас орж ирж байгаа. Тэгээд энэ татаасны гэхдээ 50 тэрбум нь БНХАУ-ын нэг компанитай хийж байгаа гэрээний татаас гэж би ойлгож байгаа. Ялангуяа оргил ачааллын үеэр эрчим хүчний дутмагшлыг арилгах үүднээс гэрээ хийсэн, 9 центээр гэж ойлгосон. Тэгээд энд зөвхөн энэ жилдээ 50 тэрбумын татаас хэрэгтэй болоод төсвийн тодотгол дээр орж ирж байгаа гэж харж байгаа. Гэхдээ энэ гэрээ ямар нөхцөлтэй хийгдсэн юм гэдэг дээр өчигдөр нэлээн хэлэлцүүлэг болсон л доо. Тэгээд 1 дүгээрт, ямар хугацаатай хийгдсэн юм бэ? Би Найдалаа сайдаас асуухад нарийн мэдээлэлгүй байх шиг байна лээ. Энэ оргил ачааллыг бууруулах зорилготой БНХАУ-тай хийж байгаа эрчим хүчний гэрээ ямар хугацаатай хийгдсэн юм бэ? Оргил бус ачааллын үеэр ч гэсэн заавал энэ эрчим хүчийг нь тодорхой хэмжээнд аваад, авахгүй бол төлбөрөө төл гэсэн ийм нөхцөлтэй байгаад байгаа юм уу? Яагаад сүүлийн хэдхэн энэ сард ингээд 50 тэрбумын татаас энэ дээр орж ирж байна гэдгийг ЭХЯ-наас асууя.

Гуравдугаарх нь, Эдийн засаг, хөгжлийн яам наашаа суугаарай. Яах вэ, ингээд бид цалин цавууны асуудал, түрүү жилийн төсвийн буруу, зөв асуудлаас болоод одоогийн энэ тодотгол дээр эмч, багш нарынхаа цалинг ингээд нэг мөр болгох гээд орж ирж байгаа, тэгэхээс өөр аргагүй ийм л нөхцөл байдал болсон. Гэхдээ энэтэй зэрэгцээд ерөөсөө шууд Өргөдлийн байнгын хороонд ч байдаг юм уу, гишүүдэд ирж байгаа асуудал бол дагаад ерөөсөө хувийн хэвшлийн ажилчид бол цалингаа нэмүүлье, ингээд төрийнхөн бүгдээрээ цалингаа нэмүүлчихлээ, бид ч гэсэн цалингаа нэмүүлье гэдэг асуудал шууд зэрэгцээд дэгдэж байна, хувийн хэвшил чинь тэгвэл яах юм бэ гэдэг асуудал явж байна. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ цалинг нэмсэнтэй холбогдуулан хувийн хэвшилд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ гэдэг ийм дүн шинжилгээ гэсэн юм хийв үү? Дагаад цалин мэдээж өснө, тэрэнтэй дагаад энэ бизнес эрхлэгч дээр хэр зэргийн дарамт ирэх юм бэ? Эсвэл дарамтаа бүтээгдэхүүнээ үнэтэй болгох замаар буюу дахиад энэ суурь үнэ маань үнэтэй болох, хэрэглээ, бүтээгдэхүүн, үйлчилгээ үнэтэй болох замаар энэ эдийн засагтаа нөлөөлөх гээд байна уу? Энэ дээр ямар нэгэн дүн шинжилгээ, анализ хийсэн юм байна уу? Хувийн хэвشلүүд дээр үзүүлэх нөлөөллийн талаар та бүхэн маань юу судалж энэ төсвийн тодотгол дээр бодлогоо гаргав гэдэг ийм 3 асуулт байна. Тэгээд эхний асуулт, 7 номер Чингис хаан баялгийн сан. 7 номерын микрофон.

Б.Даваадалай: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчтүүд нийгэмд ер нь л ачаалал үүрч ирсэн. Энэ удаад ч гэсэн эдийн засгийн нөхцөл байдал, төсөвтэй холбоотой хүндрэл дээр бас л дэмжлэг үзүүлээд оролцоод явж байгаа. Ер нь ногдол ашиг ч гэсэн төрд орж ирж байсан, Баялгийн сангаар дамжуулаад бусад хуулиараа 66-д ногдож байгаа ногдол ашиг манай дээр төрийн өмнөөс төвлөрч байгаа. Таны хэлсэнтэй санал нэг байна. Мэдээж төрийн өмчит учраас төсөв, улсын эдийн засагт гол үүргээ оруулах ёстой. Эхний хагасын байдлаар 9 их наядын борлуулалт хийсэн байна, 1.6 их наядын цэвэр ашигтай ажилласан байна. Энэ үндсэндээ 2 гол компаниас орж ирж байгаа мөнгө. Зэсийн үнэ харьцангуй бид азтай байна, өндөр байна. Нөгөө талдаа ЭТТ биет хэмжээг нэлээн нэмж байгаа. Тийм учраас оны эцэст бид 3.1 их наядын нэгдлийн хэмжээнд ашигтай ажиллахаар төлөвлөж байгаа юм. Гэхдээ энд гол бид 25 он, 2026 оны төсвийн тодотгол дээр 1 их наядын дэмжлэг үзүүлэх гэж байгаа нь ЭТТ-н өмнөх жилүүдийн ногдол ашгийн төлбөрт төрд өгөх ёстой байсан ногдол ашгийн төлбөрийг

бид авъя гэж байгаа юм. Тэгээд энэ төсөв хүндрэлтэй энэ цаг үед дэмжлэг үзүүлье гэж байгаа юм.

Яг тантай санал нэг байгаа юм ногдол ашгийн бодлогыг бид илүү тодорхой болгох ёстой, гэнэтийн биш байх ёсгүй, тогтвортой, хэзээ ямар ногдол ашгаа, яаж төсөвт болон төрд төвлөрүүлэх вэ, юунд зарцуулах вэ гэдгээ хүртэл нэлээн тодорхой болгох ёстой. Энхбаяр сайдын ахалсан төрийн өмчийн бодлогын ажлын хэсэг ажиллаж байгаа. Шинэ батлагдсан хуулийн дагуу 30 хувиа ирэх жилээс эхлээд ногдол ашиг тодорхой төвлөрөөд төсөвт төвлөрүүлнэ, нэмээд энийг юунд зарцуулах юм, яах юм, ийх юм гэдэг юмаа тодорхой болгох ёстой. Яг таны хэлж байгаа шиг эхлээд хөрөнгө оруулалтаа тооцох ёстой, тухайлбал Тавантолгой дээр далд уурхайн хөрөнгө оруулалтаа бид эртнээс эхлэх ёстой, хэчнээн хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулах юм, энийгээ тавих ёстой. Өөр ямар хөрөнгө мөнгө зарцуулах юм, тавих ёстой, үлдэгдэл дүнгээсээ ногдол ашгаа төсөвт бид ингэж төвлөрүүлнэ гэдэг тогтвортой дүрэмтэй байх ёстой.

Би сая олон улсын жишээ хараад сууж байлаа, дийлэнх нь төсөв рүү авдаг, ялангуяа Казахстаны жишээ нэлээн ойрхон юм байна. Гэхдээ эд нарын гол сургамж юу гэхээр тогтвортой дүрэмтэй бол, энийгээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиараа юм уу эсвэл ямар дүрэмтэй байх юм энийгээ тодорхой болго гээд. Тэгээд энэ дээр бид илүү тодорхой болно. Зүгээр дүгнээд хэлэхэд ТӨК-уд маань ачаагаа үүрч ирсэн, энэ жил ч гэсэн ачаагаа үүрч төсөвт дэмжлэг болж ингээд харьцангуй бид зэсийн үнэ өндөр байгаа, Тавантолгой харьцангуй нүүрсний экспортоо одоогийн байдлаар 25.5 саяыг гаргачихсан байна. Жилийн төлөвлөгөө нь 33, тийм учраас харьцангуй үзүүлэлтүүд маань сайн байгаа учраас төсөв дээрээ дэмжлэг үзүүлье гэж бодож байгаа юм. Тэгээд тантай ногдол ашгийн бодлогыг тодорхой болгох гэдэг дээр санал нэг байна.

О.Номинчимэг: Одоогоор тэгвэл тодорхой бодлого гараагүй, Засгийн газар дээр боловсруулагдаж байгаа гэж ойлголоо, Энхбаяр сайдаа? Ногдол ашгийн бодлого ТӨК-удын, тэгж байж бид цааш цаашдынхаа юманд тусах ёстой гэсэн бодлого. Өмчлөлийн бодлогоос гадна энэ төсөв рүүгээ ногдол ашгийг татаж байна шүү дээ, энэ дээр нэг тодорхой бодлого гарч байгаа юу, эсвэл жил жилдээ энийгээ шийдээд явахаар байгаа юу л гэдэг юм байгаа. Өмчлөлийн бодлого болохоор илүү нөгөө өмчилж, хувьчилж болохгүй жагсаалт гээд янз бүрийн юмнууд байгаад байгаа юу. ЭХЯ яаж байна, хаана байна, 9 номер Эдийн засаг, хөгжлийн яам тэр үед хариулж байгаарай. Хувийн хэвшил дээр өгөх цалингийн ачаалал эргээд энэ маань эдийн засагт яаж нөлөөлөх вэ гэдэг дээр дүн шинжилгээ, 9 номер.

О.Мягмардорж: Эдийн засаг, хөгжлийн яам Мягмардорж, гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамнаас болохоор яг инфляцын ирэх жилийн нөлөөн дээр, цалингаар дамжиж орж ирэх эрэлтийн инфляц дээр яг ямар хэмжээний нөлөө үзүүлэхийг тооцож үзсэн. Эдийн засагт 1 их наядын мөнгөний нийлүүлэлт хийвэл эрэлтийн инфляцыг 0.5 нэгжээр өсгөх гэсэн судалгаа хийгдсэн байгаа. Өнөөдөр үүсээд байгаа инфляцын бараг 60 орчим хувь нь нийлүүлэлтийн гаралтай байна. Үүн дотроо задлаад яривал, махны инфляц нийт 13 хувийнхаа 5 нэгжийн хувь нь мах, 1.2 нь шатахуун, 0.7 нь хүнсний ногооны өсөлтөөс шалтгаалсан байна. Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн тодотгол бүхэлдээ ирэх жилийн нийлүүлэлтийн гаралтай инфляцыг бууруулахад чиглэж байгаа. Эдгээр бүтээгдэхүүнүүдийн нөөц, сав болон нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарсан. Эргүүлээд өрхийн бодит орлогыг хамгаалах чиглэл болохоороо багш, эмчийн цалин

болон тэтгэврийн хэмжээг ирэх оноос ихэсгэж, өсгөж нэмэгдүүлэхээр тооцсон. Нэмээд Татварын багц хууль батлагдсантай холбогдолтойгоор эргүүлэн иргэдэд 1 их наядын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлж байгаа. Энүүгээрээ дамжаад.../минут дуусав/

О.Номинчимэг: Иргэдийнхээ орлогыг хамгаална гэдгийг ойлгож л байна л даа. Гэхдээ иргэдийн орлогоо хамгаалангаа энэ чинь цалин өсөөд явчихаар чинь эргээд компаниуд, хувийн хэвшил яах вэ гэхээр энэ зардлыг нөгөө хэрэглэгч дээр л гаргаж байгаа шүү дээ. Эдийн засгийн ойлголт байгаа, тийм үү? Тэгэхээр энэ чинь энэ компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээ өөрөө дахиад үнээ нэмнэ л гэсэн логик байгаад байдаг, тэгээд энийг сэргийлсэн янз бүрийн бодлого эд нар байна уу? Би энэ төсвийн тодотголтой холбоотой мах, хүнсний бүтээгдэхүүний үнийн хөөргөдлийг хязгаарлах, шатахууны сав гээд энэ татааснуудыг бодлогын хүрээнд хүргэж, ялангуяа махны үнэтэй холбоотой энэ маш сайн юуг агуулах, савны асуудлаас эхлүүлээд анхаарч байгааг дэмжиж байгаа. Гэхдээ эргээд наадах чинь зөвхөн мах, хүнсний ногоо биш, суурь инфляц дээрээ яаж нөлөөлөх гээд байна гэдэг дээр та хэд далайцтай дүн шинжилгээ хийв үү л гэдэг асуулт байна. Энийг л бүгдээрээ ер нь асуугаад байгаа, хариулт авчихвал маш сайн байна. Төсвийн тодотгол бол өөрөө яалт ч үгүй хийхээс өөр аргагүй нөхцөл байдалтай байгаа, хийх ч ёстой, Тэрэн дээр тооцоо судалгаа байна уу л гэдэг асуудал. 9 номер.

О.Мягмардорж: Эдийн засаг, хөгжлийн яам Мягмардорж. Яг эдийн засгийнхаа өсөлтийг ер нь задлаад харвал, эцсийн ашиглалт талаасаа харвал гадаад дэгдэлт аягүй сайн байгаа, харин дотоод идэвхжил дийлэнхүүдээ уначхаад байгаа юм. Энэ болохоор яг өрхийн хэрэглээн дээр 23 оноос анх удаа агшилттай орж ирсэн. Тэгэхээр ирэх жилийн яг төсөл дээр болохоор бид хөрөнгийн зардал дээр нийт 10 их наядын хөрөнгө оруулалт хийхээр тусгасан, энүүгээрээ дамжаад эдийн засгийнхаа дотоод идэвхжилийг ер нь нэмэгдүүлэхээр тооцсон.

О.Номинчимэг: ЭХЯ, 8 номер.

Б.Ерэн-Өлзий: ЭХЯ-ны ТНБД Ерэн-Өлзий, Номинчимэг гишүүний асуултад хариулъя. БНХАУ-аас Оюутолгойн уурхайг хангаж байгаа 220 киловольтын шугам байдаг, энэ шугамыг ашиглаад Оюутолгойн дотоодын үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчний системтэй, сүлжээтэй холбоогүйгээр Монгол Улсын төвийн эрчим хүчний системд цахилгаан эрчим хүч импортолж авах энэ боломжийг нээх хөрөнгө оруулалтын ажил өнгөрсөн онд хийгдэж, сая 8 сард ашиглалтад хүлээж авсан. Энэ 220 киловольтын хуваарилах байгууламж юм байгаа юм. Үүнтэй уялдуулаад Монгол Улсын Диспетчерийн үндэсний төвөөс Өвөр Монголын эрчим хүчний сүлжээ компанитай Цахилгаан эрчим хүч худалдах гэрээ өнгөрсөн он, 25 оны 12 дугаар сарын 12-нд байгуулсан. Энэ гэрээний агуулга болохоор Өмнөд говийн.../минут дуусав/

О.Номинчимэг: Товчхон, тодорхой ямар хугацаатай, ямар нөхцөлтэй гэдгийг нь хэлэх боломжтой бол хэлээдхээч, 8 номер.

Б.Ерэн-Өлзий: Энэ гэрээ 5 жилийн хугацаатай, 1 квт.цаг нь 0.58 юань буюу ойролцоогоор 9 цент гэсэн үг. Гэрээний үнийг жил болгон шинэчилнэ. Диспетчерийн үндэсний төв ямар хэмжээний цахилгаан худалдаж авахаа 1 сарын өмнө худалдаж авч байгаа талдаа захиалга өгч баталгаажуулна. 2026 оны хувьд бид 8 сараас 12 сар хүртэл нийтдээ 160 сая квт.цаг цахилгаан эрчим хүчийг худалдаж авна гэж

төлөвлөсөн байгаа. Гол хэмжээ нь болохоор яг өвлийн оргил ачааллын саруудад 80 мвт хүртэлхийг худалдаж авахаар төлөвлөсөн байгаа. Үүнд нийтдээ хэрэглэгчийн үнэ тариф болон импортын эрчим хүчний тарифын зөрүүтэй холбоотой 51 тэрбум төгрөг зарцуулахаар байгаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Гишүүд асуулт асууж дууслаа. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. 4 гишүүнээр тасаллаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Энэ төсөв зөвхөн нягтлан бодох бүртгэл гэхээсээ илүүтэй хүний хөгжлийн бодлого, тэр утгаараа ч цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх, тэгээд төсвийн тодотголыг ингэж оруулж ирж байгаа нь зүйтэй байна. Тэгэхдээ энд нэг хэд хэдэн л юм хэлмээр байна. 1 дүгээрт, тэр Төрийн нарийн хариулснаар тэр эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилт, өр төлбөр, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж болон үйл ажиллагааны бодит нөхцөл байдлын талаар хийсэн тэр судалгаагаа Байнгын хорооны гишүүдэд эсвэл надад зөвхөн ирүүлнэ үү.

2 дугаарт, энэ цалинг нэмэхдээ эрүүл мэндийн салбарын, төрийн бусад үйлчилгээний салбарын ерөнхий дунджаар механикаар жигдрүүлэх биш, харин эмч, сувилагч болон бусад ажилтны мэргэжлийн ур чадвар, ялангуяа ажлын тэр бодит ачаалал, хөдөлмөрийн нөхцөл, эрсдэл, тэгээд хариуцлагад тулгуурласан тийм тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай байгаа. Энэ нэг цалингийн нэмэгдэлтэйгээ, сайн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдалтайгаа уях ёстой, энэ тал дээр ямар бодлого ЭМЯ-наас гаргаж ирж байгаа гэдгийг бас бичгээр ирүүлмээр байна. Амаараа бол энд хариулт би авч чадахгүй байх. Яагаад гэхээр 1, 2 жилийн талаар ер нь ярьж байгаа.

3 дугаарт, тэр ЭМД-ын сангаа яг орлого, зарлагатай тодотголоор гаргаж байгаа өөрчлөлтөө яг хэд хэдэн юмаар ингэж хуваагаад, яг категоричлоод ирүүлбэл их сайн байна. Даатгалын шимтгэлийн орлого, төрөөс хариуцах иргэдийн шимтгэл гэж байгаа. Төр хариуцаж байгаа тусламж үйлчилгээний санхүүжилт, эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал, тэгээд эмийн үнийн хөнгөлөлт, сангийн өр төлбөр, өглөг болбол жилийн үлдэгдэл нь юу болох вэ гэдгээ тэр хугацааг нь дөхүүлж байгаад. Одоогоор яг ЭМД-ын сангаар санхүүжүүлэх гээд эрүүл мэндийн байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагуудаар явахаар хот хөдөөгүй гарч байгаа асуудлууд нь бид нар ингээд төлөгдөөгүй нэхэмжлэлүүд маш их байна л гээд яриад байгаа байхгүй юу. Маш их гэдэг нь яг ингээд нэгтгэсэн тоогоороо яг хэд байгаад байгаа юм, хэдэн төгрөг байгаад гэдгийг мэдмээр байх юм. Тэр нь шатлалаар нь байвал их сайн байна.

Тэгээд яг хэдэн байгууллагууд төрийнх бөгөөд хувийн ялангуяа санхүүжилт нь хүлээгдэж байгаа вэ? Тэгээд энэ оны эцэс хүртэл үүсэх санхүүжилтийн дутагдлыг хэдээр тооцоод энэ гүйцэтгэлээ хааж дуусгана гэж сая судалгаатай хийж байгаа гэж ярьсан. Тэрийгээ бичгээр оруулж өгөөрэй. KPI гээд түрүүн хариулах гээд амжаагүй байх, тэгэхдээ 2020 оны эцэст нь хүрэх үед гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ суурь түвшин, хүрэх зорилтот түвшин, хэмжих аргачлал, тайлагнах хугацаа, хамгийн гол нь хариуцах байгууллагатайгаа оруулж ирвэл маш сайн байна. Ийм хэдэн саналыг хэлье, баярлалаа.

О.Номинчимэг: ЭМЯ, Ганмаа гишүүний хэлсэн энэ мэдээллүүдийг бичгээр тэгээд гишүүнд хүргүүлчихнэ биз. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн үг хэлье.

Ц.Мөнхтуяа: Ер нь миний анзаарч байгаагаар манай энэ төрийн бодлого нэг их том том гоё, чихэнд чимэгтэй зорилго, зорилтууд дэвшүүлнэ. Энэ нь ерөөсөө тэр хөрсөн дээр бууж, ард иргэдийн амьдралд очиж байгаа юм үнэхээр бага байна, наалдаж байгаа юм байхгүй байгаа, ард иргэдийн амьдрал өдрөөс өдөрт хэцүү болж байна, инфляц өсөж байна. Тэгээд ийм байхад бид их сайн ажиллаж байна, Монгол Улс их сайхан хөгжиж байна гэж ярих ямар ч боломж алга. Тэгээд үг хэлэхгүй гээд яах вэ, хэлье дээ.

2026 оны төсвийн тодотголыг энэ хэвээр нь дэмжих боломжгүй миний зүгээс. Энэ зөвхөн багшийн цалингийн асуудал биш юм. Хүмүүс болохоор энэ Мөнхтуяа зөвхөн багшийн цалин яриад байна гэж ойлгоод, буруу ойлгоод байна, маш буруу ойлгож байна. Энэ чинь өөрөө УИХ өөрийн баталсан шийдвэрээ өөрөө хэрэгжүүлэх эсэх тухай зарчмын асуудал ярьж байгаа би. УИХ өөрөө чуулганаар гишүүд баталчихсан шүү дээ, тэгээд өнөөдөр энд маргалдаад байх ямар ч асуудалгүй шүү дээ. Баталсан юмаа эргүүлээд өөрсдөө буруутгаад, үгүйсгээд байх юм. 2025 оны 5 дугаар сарын 29-нд Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг УИХ баталсан, батлахдаа багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг тэргүүн ээлжид сайжруулна гэж заасан. Үүнээс 6 сарын дараа буюу 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-ын 109 дүгээр тогтоолоор энэ зорилтыг улам тодорхой болгож, 2026 онд багшийн үндсэн цалинг 2 сая 800 мянган төгрөгөөс доошгүй түвшинд хүргэнэ гэж баталсан. Тэгээд өнөөдөр нөгөө 2 сая 800 болсон уу, болоогүй юу гэж асуухаар ямар ч Ерөнхий сайд нь ч тэр, Сангийн сайд нь ч тэр миний асуултад бүрэн хариулаагүй өчигдөр Их Хурлын чуулган дээр.

Мөн уг зорилгын санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Засгийн газарт даалгачихсан, УИХ өөрийн баталсан 2 сая 800 мянган төгрөгийн зорилгоо хэрэгжүүлэх юм уу, хэрэгжүүлэхгүй юм уу гэдгийг л би асуугаад байгаа юм. Төсвийн тодотгол УИХ-аас шинээр баталсан бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг тусгах боломж гэж харж байгаа. Тэгээд энүүгээр асуудал дуусахгүй, дахиад бид 2027 оны улсын төсөв хэлэлцэнэ. УИХ баталсан 5 жилийн үндсэн чиглэлээр багшийн үндсэн цалинг цаашид улсын дундаж нэрлэсэн цалингаас доошгүй түвшинд хүргэх зорилт тавьсан байгаа. Тэгээд 2026 оны 2.8 сая төгрөгийн зорилтоо өнөөдөр хэрэгжүүлж чадаагүй байгаа хүмүүс 2027 оны зорилтоо маргааш яаж хэрэгжүүлэх юм. Тийм болохоор энэ хөгжлийн бодлого нь нэг тийшээ хараад, улсын төсөв нь нөгөө тийшээ явж болохгүй.

Тийм учраас би УИХ-ын эрхэм гишүүддээ уриалмаар байна, энэ орж ирж байгаа төсвийн тодотголыг баталж болохгүй гэж би хэлмээр байна. Засгийн газрын төсөв парламентын баталсан бодлогод нийцэх ёстой шүү дээ. Тэгээд Засгийн газар нь Их Хурлынхаа дээр гарчихсан юм шиг ийм байдалтай биднийг загнаад сууж байна шүү дээ. Тэгээд Дэгийн тухай хуулийн 70.5-д төсвийн төсөл холбогдох хууль болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэхээр санал хураахаар заасан байгаа шүү дээ Дэгийн тухай хуульдаа. Тэгээд Дэгийн тухай хуулийн 70.7-д энэ санал хураалтыг олонх дэмжээгүй бол төслийг хуульд нийцүүлэн дахин өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт буцаахаар зохицуулсан, цагаан дээр хараар бичсэн энэ зохицуулалт нь байж байна. Тиймээс би энэ төсвийн тодотголыг дэмжихгүй, УИХ-ын эрхэм гишүүддээ ч уриалж байна, ийм байж болохгүй.

О.Номинчимэг: Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Баярлалаа. Яах вэ, нэг үеэ бодвол бид энэ нийгмийн зорилтот бүлгийн хүн амын талаар зөндөө анхаарч байгаа, зөндөө олон ажлууд хүртээмж дээр анхаарч байгааг үгүйсгэх аргагүй, маш олон ахицууд гарч байгаа. Гэхдээ ингээд нөгөө мөнгө зарцуулаад, зөндөө олон ажил хийгээд байгаа мөртөө тэр нь яг ингээд зорилтот бүлэгтээ хүрэхдээ оновчтой биш байна гээд байгаа юм. Тэгвэл оновчтой биш юм бол ямар хүмүүст нь яг зөв үйлчилгээ хүрэх юм, яаж хүрэх юм гэдэг аргачлалыг ярьж гэхээр яг тэрийг хийх ёстой бүтэц, тэр хөгжлийн бэрхшээлтэй хүний жишээн дээр агентлаг байгаа байхгүй юу. Гэтэл агентлаг өнөөдөр 7 жилийн хугацаанд байгуулагдаад, тэрнээс хойш 8 удаа агентлагийн тэргүүн солигдсон, 2019 онд байгуулагдсанаас хойш 8 удаа тэргүүн нь солигдож байна шүү дээ. Тэгэхээр энэ удирдлага тогтворгүй байгаа үед энэ бодлогыг гаргах механизм олигтой явж чадахгүй байна л даа. Тэгээд бүх яам болон салбар Засаг дарга нар дэргэдээ ийм албадтай, салбар зөвлөлтэй гээд байгаа. Тэр зөвлөлөө олигтой ажиллуулах энэ бүтцээ дэмжихгүй, зарим яам төсөвтэй, зарим яам төсөвгүй.

Тэгэхээр энэ ер нь нэг ийм 110 мянган хүний асуудал юм шиг харагдаад байгаа ч гэсэн, энэ чинь өөрөө цаана нь гэр бүлийн хүмүүс байгаа гээд бодохоор 3, 4 зуугаад мянган хүний асуудал явж л байгаа шүү дээ нэг хүнийг дагаад нэг хүн асарч байна гээд. Тэгэхээр би энэ улсын төсвөөс ингээд харахыг хүссэн зүйл мэдээж хэрэг хүртээмжийн зардлыг оновчлох байсан. Энэ маш сайн хэрэгжилттэйгээр ингээд орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Гэхдээ бид энэ жил улс орон даяар цуглуулж амжсангүй, хэлэлцүүлэг дээр хийх болно. Нөгөө талдаа яагаад зардал руу нь ороод байгаа гэхээр, тэр 10 мянган төгрөг байна уу, 100 мянган төгрөгийг яг юунд зарцуулаад, ямар үр дүн гараад байгаа тайланг нь харахаар оновчтой биш байгаад байгаа байхгүй юу. 2026 оны төлөвлөлтийг харахаар яг хэдэн хүн ажилд орсон юм бэ гэхээр ажилд орсон хүнийх нь тоо, тэр ажлын байран дээр тогтвортой байгаа хүний тоо байхгүй. Тэгэхээр ингээд яг энэ зорилтот бүлгийн хүмүүст зориулсан төсөвлөлтийг харахаар ийм оновчтой биш байгаад байна л даа.

Хөдөлмөр эрхлэлтийг яриад байгаа мөртөө хөдөлмөр эрхлэлт нь ерөөсөө бэлтгэгдэхгүй байгаад байна. Хүнийг шууд ажилд оруулах, эсвэл шууд бизнес хий гээд ингээд бизнесийн суурьгүй ч юм уу хүмүүст аваачаад мөнгө өгчихнө. Тэгээд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөв гээд бараг 40, 50 ажилтантай байгууллага тэнд байгаад байдаг, гэтэл хүмүүс ажилд орж чаддаггүй. Халамж яриад байгаа мөртөө бие даахад нь ерөөсөө бэлтгэхгүй, бэлэн мөнгөний дэмжлэгээс гадна тэр сэргээн засах тэр ур чадвар, боловсрол, бие даах асуудал руу нь хөрөнгө оруулалт ерөөсөө байхгүй, дандаа л нэг тийм мөнгөн дэмжлэг өгчхөөд л хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ингэсэн шүү гээд байгаа. Сэргээн засалтыгаа зөвхөн эмчилгээний дараа гэж дандаа үзнэ, гэтэл сэргээн засал гэдэг юм чинь өөрөө хамт явах ёстой. ЭМЯ-наас энэ талаар ингээд нэг сэтгэл гаргаад, мэдээлэл гаргаад ерөөсөө өгчихгүй байгаад байдаг.

Тэгээд эмнэлэг аягүй их барьж байна гээд байгаа, эмнэлэг баригдана гэж байгаа, гэтэл эмнэлэг дотор нь ер нь хэд нь сэргээн засалтын агуулгатай гэдэг тоог би асууж байна, ЭМЯ энэ талаар мэдээллээ оруулах хэрэгтэй. Хэдэн эмнэлэг өнөөдөр дэргэдээ сэргээн засгаа авч явах юм, цочмог үеийнхээ сэргээн засалтаа дэргэдээ яаж авч явах юм, тэр асуудал байхгүй. Тэгэхээр ингээд халамж, эмнэлэг яриад байгаа эмчилье гээд байгаа мөртөө сэргийлэхгүй, халамж яриад байгаа мөртөө бие даахад нь бэлдэхгүй, хөдөлмөр эрхлэлтийг ярьдаг мөртөө хөдөлмөр эрхлэлтэд нь бэлдэхгүй, тэгээд ингээд ерөөсөө нэг ийм оновчгүй ийм төсөв мөнгөөр

ингээд зөндөө их зарцуулалт хийчхээд байгаа юм. Тэгэхээр энийг чинь ингээд хөгжлийн бэрхшээлтэй хүний төсөв хасагдаагүй л гэж байгаа юм, хасагдаагүй байна, ойлголоо. Гэхдээ аль хэсэгт нь юуг нь байршуулаад хэдэн хүнийг амьдралд бэлдэх гээд хөл дээр нь тогтоогоод байгаа юм бэ, босгоод байгаа гээд харахаар байхгүй болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр оновчгүй зарцуулалтаа эргэж харъя гээд байгаа шүүдээ. Хэрэв мөнгийг оновчгүй зарцуулаад ингээд сайхан сэтгэл гаргаад байвал энэ чинь мэдлэггүй сайхан сэтгэл гэдэг чинь тэнэгийн дүү гэдэг үг байдаг биз дээ, ийм болох гээд байна шүү дээ энэ манай халамж, нийгмийн даатгал, гэр бүл, ЭМЯ-ныхан. ICF-ээ хурдан яаравчил, тэгээд тэр судалгаагаа оновчтой хиймээр байна шүү дээ.

О.Номинчимэг: Жанчивын Галбадрах гишүүн үг хэлье.

Ж.Галбадрах: Төсөв гаргахдаа бид нар яаж, хэрхэн эрэмбэлдэг вэ гэдгийг л гаргамаар байна. Аль салбарыг, хүний хөгжил хэддүгээрт нь гэчихдэг юм, боловсрол тэргүүлэх салбар мөн үү? Ингээд жишээлбэл, энэ төсвийн хөрөнгө оруулалт нэмэлтээс, төсвийн хөрөнгө оруулалтаас 272 тэрбум төгрөг хэмнэнэ гэсний дотор 33 тэрбум гэнэ, нэг цэцэрлэг байх шиг байгаа юм, нэг сургууль байх шиг байгаа юм, спорт заал энэ тэр гээд эд нарыг хасна гээд 33 тэрбумыг хэмнэе гэсэн ийм жишээ нь байж байх жишээтэй. Би түрүүн асууж амжаагүй л дээ, тэгэхдээ ийм зардлыг битгий хасаарай. Энэ сургууль, цэцэрлэгээс хэдүүлээ нэгэнт төсвийнхөө тэр шаардлагыг хангаад ороод ирсэн бол битгий хасаарай гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

Тэгээд боловсрол ерөөсөө бүх зүйлийг шийднэ. Боловсрол, чанартай боловсрол олж авах танхимд сурч, зүгээр ном уншиж цээжлэх үйл явц биш байгаа. Бие сэтгэлийн орчны аюулгүй байдал, нийгэм сэтгэл зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх ийм цогц нэгдлийг бид боловсрол гэж ойлгож байх ёстой. Тэгэхээр жинхэнэ хөгжлийн суурь энэ боловсрол юм. Тэгэхдээ энэ боловсрол нь стандарт орчин, зориулалтын сургалтын байртай, сургууль нь чанартай боловсрол олгодог тийм л газар явах ёстой, бид энэ нөхцөлийг бүрдүүлж чадах юм бол ерөөсөө л Монгол орны хөгжлийн түлхүүр нь энд л байгаа. Тэгээд энэ чанартай боловсрол дотор сая зөвхөн анги танхимаар өгдөг мэдлэг олгохоос гадна зүрх сэтгэлийн боловсрол, манай Их Хурлын гишүүд дотор энэ талаар ярьдаг олон гишүүд байна, бүр туршлагатай хүмүүс олон байж байна. Тэгэхээр энэ асуудлыг л бид шийдэх тал дээр дорвитойхон шиг тавьж орж ирэх ёстой, Боловсролын яамыг энэ чиглэл дээр нь, зөөлөн ур чадварын тал дээр анхаараасай гэж хүсэж байгаа юм.

Тэгээд чанартай боловсрол Монголын нийгэмд ямар, ямар асуудлуудыг шийдэх вэ гэвэл ерөөсөө салбар болгонд тулгараад байгаа бүх л асуудлыг шийднэ. Хөдөлмөрийн зах зээлийн зөрчил гадагш дайжихгүй. Монголд ажилгүйдэл өндөр байгаа ч гэсэн, ажил олгогчид шаардлага хангах ажилтан олдохгүй байна л гээд байгаа шүүдээ. Тэгвэл тэр боловсрол сайжрах юм бол энэ шаардлага хангасан ажилтан гэдэг маань гарч ирнэ. Дээд сургууль төгссөн залуус багшийн заасан хоосон онолоос өөр юмгүй байгаад байна шүү дээ. Тэгвэл энэ дээд боловсролоо чанаржуулъя. Хичээлээс гадуурх энэ хөтөлбөрүүдийг миний энэ онцолж хэлээд байгаа энэ дээр ерөөсөө ингээд төсөв дээр юм нь тусаж орж ирэхгүй, тэгээд нэг тохиолдлын чанараар арга хэмжээнүүдэд нэг хөтөлбөр хийгээд дуусчихдаг. Энийг ингээд тогтвортой жилийн туршид ингээд хийгээд явбал Монгол залуусын маань дотоод, өөрсдийнх нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд маш их ийм чухал зүйл байгаа.

Тэгээд залуусын сэтгэцийн эрүүл мэндэд энэ их нөлөөтэй. ЕБС-ийн хүүхдүүд, оюутнуудын дунд энэ дээрэлхэлт, амиа хорлолт, янз бүрийн энэ сэртхийлгэм ийм асуудлууд олон гарч байна. Тэгэхээр энэ тал дээр бид өсвөр насныхны энэ сургуулийн орчинд, энэ дээрэлхэлтийн асуудлуудыг, бид чинь өндөрт ордог, бүс нутагтаа өндөрт ордог улс болчихсон байна. Тэгээд энийг түрээсийн давчуу орчинд бид ингэж цуглуулж, стрессийг нь бухимдуулж байснаар энэ улам л дэврээнэ үү гэхээс, тэр орчноо бүрдүүлэхгүй бол энэ шийдэгдэхгүй. Баян хоосны ялгаа буюу нийгмийн тэгш бус байдал, улсын сургуулиудын орчныг стандартад хүргэж, чанартай хөтөлбөр олгосноос л орлого багатай айл өрхийн хүүхдүүдэд амьдралаа өөрчлөх тэр боломжийг нь өгч байгаа, нийгмийн хамгийн хүчтэй дэмжлэг болж, нийгмийн тэгш бус байдлыг л одоо хэдүүлээ багасгахын төлөө л энэ төсөв маань зориулагдах ёстой гэдгийг хэлмээр байна. Тэгээд л одоо бүр энгийн жишээ хэлэхэд, Монгол Улс агаарын эрс тэс уур амьсгалтай, өвөлжилтийн агаарын бохирдолтой, хүйтэн байдаг учраас хүүхдүүд гадаа тоглож чаддаггүй, тэр сургууль дотор л байдаг, сургууль дотор нь спорт заалтай байгаад, спорт заалгүй жишээлбэл, агааржуулалт муу байх юм бол тэр хүүхдүүд өвчлөл нь ихсээд.../минут дуусав/

О.Номинчимэг: Гишүүд төсвийн тодотголтой холбоотой үг хэлж дууслаа. Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа. Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Төсвийн байнгын хороонд Галбадрах гишүүн танилцуулчих уу санал, дүгнэлтийг Байнгын хорооны. Галбадрах гишүүн.

17.17 цаг

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Өргөдлийн байнгын хорооны хурал хаалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА